

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2006 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### 1. НИЙГМИЙН БОДЛОГО

**Нийгмийн хамгаалал.** Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 5000 төгрөгөөр буюу 32.0 хувиар нэмэгдүүлж, 20480 төгрөгт хүргэхээр болов.

- *Нийгмийн халамжийн тэтгэврийн нэмэгдэлд 44.7 мянган хүн хамрагдаж 2.4 тэрбум төгрөг зарцуулна. 1998 оны 7 дугаар сарын 1-нээс өмнөх тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын хэмжээг 120.000 төгрөгөөр хязгаарлаж байсныг хүчингүй болгон, төсвөөс жилд 1.9 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар болов.*

Төрийн албан хаагчийн болон төсөвт байгууллагад ажиллагсдын цалингийн хэмжээг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан 30 хувиар нэмэгдүүллээ.

- *2006 оны жилийн эхний суурь цалинтай харьцуулахад улсын төсвөөс нийт 46.8 тэрбум төгрөг зарцуулж, төсөвт байгууллагын цалингийн сан 190.0 тэрбум төгрөгт хүрнэ.*
- *Цалин нэмэх арга хэмжээнд төрийн болон төсөвт байгууллагын нийт 124.6 мянган ажиллагсад хамрагдаж байгаа бөгөөд төрийн албан хаагчдын дундаж цалин 105 мянга төгрөгт хүрч байна.*

“Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2004 оны 42 дугаар тогтоолыг 2004 оны 2 дугаар сарын 15-наас эхлэн хэрэгжүүлэхдээ Төрийн албан хаагчийн цалинг 7.5 хувиар нэмэгдүүлж, цалингийн сангийн үлдэж байгаа 17.5 хувьтай тэнцэх хэсгийг мөнгөн урамшууллын хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард **53000** төгрөг буюу нэг цагт **313** төгрөг **61** мөнгө байхаар тогтоолоо.

“Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Гэр бүл, хүүхдийн мөнгөн тэтгэлэг, тусламжийн тухай хуулийн төсөл, “Тэтгэлэг, тусламжийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлээд байна.

- ✓ *Хүүхдийн мөнгийг 0-18 насны бүх хүүхдэд олгох, анх удаа гэрлэж байгаа залуу гэр бүл, шинээр мэндэлсэн хүүхдэд мөнгөн тусламж олгох, тэтгэлэг тусламжийн хэмжээг УИХ-аас тогтоохоор тусгав.*

“Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслүүдийг УИХ-аар батлуулав.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд заасныг үндэслэн “Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоол гаргав.

- *Тогтоолоор орон сууцны хөлс, түлээ нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 50000 төгрөгөөр, Монгол Улсын болон хөдөлмөрийн баатар, ардын цолтон, ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөр/-т улирал бүр олгох мөнгөн тусламжийн хэмжээг 50000 төгрөгөөр, Монгол Улсын гавъяат болон төрийн соёрхолт, түүнчлэн Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, “Алдарт эх” I одонтой ахмад настанд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 100000 төгрөгөөр, “Алдарт эх” II одонтой ахмад настанд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн*

*хэмжээг 50000 төгрөгөөр, ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй, насанд хүрсэн бүрэн хараагүй иргэнтэй өрхийн суурин телефон утасны төлбөрт сар бүр үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг 10000 төгрөгөөр тус тус тогтоож, 2006 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдүүлэхээр боллоо.*

“Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 20480 төгрөгөөр, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгох мөнгөн тэтгэмжийн хэмжээг сард 20000 төгрөгөөр, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг сард 20000 төгрөгөөр тус тус тогтоож 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр тогтоолын төсөлд тусгаад байна.

БНСУ-ын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр гарын үсэг зурсан “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Засгийн газрын 2006 оны 134 дүгээр тогтоолоор баталлаа.

- *2700 гаруй Монгол иргэд Солонгос Улсын тэтгэврийн санд хөдөлмөрийн хөлснөөсөө төлж буй 1.4 тэрбум орчим вонны шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөгдөж байна.*
- *Монголд хөдөлмөрлөж байгаа Солонгос Улсын иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөх юм.*
- *Манай иргэдийн хөдөлмөрийн хөлснөөс авах төлбөрийн хэмжээ буурч, тэнд ажилласан хугацааны НДШ нь тэтгэврийн даатгалын нэрийн дансанд бичигдэж нийгмийн хамгаалал нь баталгаажих юм.*

Нийгмийн халамжийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор “Амьжиргаанд туслах халамжийн хөтөлбөр”, “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн хөтөлбөр”, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөр”-ийг батлуулав.

Нийгмийн халамжийн тухай багц хуулиудыг дагаж гарах журам, дүрмүүдийг батлуулав. Эдгээр хууль тогтоомж, журам дүрмийг хэрэгжүүлэх чиглэлээр боловсон хүчнийг чадавхижуулах сургалтыг 21 аймаг, нийслэлийн дүүргүүдэд сургалт зохион байгуулж байна.

Хүн амын хөгжил. “Хүн худалдах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” асуудлаарх хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

- *Хэлэлцүүлэг нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрийн болон ТББ-аас хэрхэн хамтарч ажиллах, төр засгаас баримтлах бодлогын чиглэлийг тогтооход чухал ач холбогдолтой боллоо.*

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенцийн Засгийн газрын ээлжит тайланг боловсруулан, олон нийтийн санал бодлыг тусгах зорилгоор телевиз, радиогийн шууд ярилцлага, хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, нээлттэй утас, цахим хэлэлцүүлгийг ажиллууллаа. Төр, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэдний эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн амьралд оролцох оролцоог нэмэгдүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ойлгуулах, ил тод байдлыг хангах чухал ач холбогдолтой боллоо.

Хөдөлмөр эрхлэлт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулав.

- *Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, албан бус хөдөлмөр эрхлэгчид, малчдыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах, хөдөлмөр эрхлэлтийн шинэ үйлчилгээ, арга хэмжээг нэвтрүүлэх чиглэлээр хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа.*

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг өргөжүүлснээр уг арга хэмжээнд жилд 21290 иргэн, үүнээс 3.5 мянган малчин, 3.0 мянган албан бус хөдөлмөр эрхлэгч, 9.0 мянган эмзэг бүлгийн иргэд нэмж хамрагдах боломжтой болох юм.

“Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолыг батлуулав.

- Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг төрийн үйлчилгээгээр дамжуулан албажих боломжийг бүрдүүлэх, эрсдлээс хамгаалах эрх зүй, эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгааг бий болгон улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг тоо, чанарын хувьд сайжруулан хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломж бүрдэх юм.

2006 онд гадаадаас авч ажиллуулах ажиллах хүч, мэргэжилтний хувь хэмжээг тогтоолоо.

- Хувь хэмжээг тогтоох нь гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог хөдөлмөрийн дотоод зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулах, шинээр бий болсон ажлын байранд монгол иргэдийг ажиллуулах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

“Барилгын салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх тухай” Засгийн газрын тогтоол батлуулав.

- Тогтоолоор барилгын салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд зарцуулах эрхийн бичгийн хэмжээ болон нэгж зардлыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг жил бүр хийж ажил олгогч, нийт иргэдэд мэдээлж байхаар болов.

“Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилтны дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийг угтсан ажлын хүрээнд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шинэчлэл-2006” үзэсгэлэнг зохион байгуулав.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг “Хүүхдийн хөдөлмөрийг устгах нь хүрч болохуйц зорилт” уриан дор тэмдэглэх ажлыг зохион байгуулав. Сарын ажлын хүрээнд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нөхцөл байдлын талаар хийсэн судалгааны дүнг танилцуулах уулзалт, “Хүүхдийн хөдөлмөрийг устгах нь хүрч болохуйц зорилт” Дэлхийн илтгэлийг танилцуулах зөвлөгөөн зэрэг цуврал арга хэмжээг зохион байгууллаа.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 95 дугаар чуулганд гишүүн 178 орноос 166 орны 2684 төлөөлөгчид гурван талт бүрэлдэхүүнээр оролцлоо. Чуулганд НХХ-ийн сайд Л.Одончимэд хөдөлмөрийн суурь зарчмууд ба эрхүүдийн тухай ОУХБ-ын тунхаглалын талаарх Ерөнхий захирлын дэлхийн илтгэл болон Чуулганаас дэвшүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйл ажиллагааг дэмжих хүрээ бий болгох конвенци, зөвлөмжийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлж үг хэллээ.

- Чуулганы үеэр БНТУ-ын Засгийн газрын төлөөлөгчидтэй уулзалт хийж, Монгол Улсын НХХЯ болон Туркийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд хамтран ажиллах тухай санамж бичгийн хэрэгжилтийг хангах, өргөжүүлэх чиглэлээр харилцан санал солилцлоо.
- ОУХБ-ын Сургалтын төвийн захиралтай уулзаж, Монголын хөдөлмөр, нийгмийн салбарын ажилчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхтэй холбогдуулан ОУХБ-ын Турины төвд зохиогддог сургалтад хамруулж байх, манайхаас нэр дэвшүүлж буй хүмүүст тэтгэлэг олгож байх боломжийн талаар санал тавилаа.
- БНСУ-ын хөдөлмөрийн сайдтай уулзаж, сайдын Монгол Улсад хийх айлчлалын үеэр яам хооронд хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурахаар тохиролцов. Ингэснээр хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын

цаашдын хамтын ажиллагааны эхлэл тавигдах бөгөөд салбарын боловсон хүчнийг БНСУ-ын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, харилцан туршлага мэдээлэл солилцох боломж нээгдэх юм.

Хүүхдийн асуудлаар. УИХ-ын дэргэд “Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих 12 гишүүнтэй “Лобби бүлэг” байгуулах, “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хоёр дахь шатны /2005-2007/ үйл ажиллагааны чиглэлийг баталж, “Хурдан морины уралдааны дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулав.

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Үндэсний чуулган”, “Хурдан морь унаач хүүхдийн Үндэсний чуулган” зохион байгуулж, хүнд нөхцөлийн хүүхдийн эрхийг хамгаалахад төр, олон нийтийн анхаарлыг хандуулж, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэв.
- “Боржигоны хүүхдүүд” урлагийн наадам, “Алунгоо эхийн сургаал” хичээл болон “Их Монголын хүүхдүүд” хүүхдийн баяр ба Карнавал зэрэг томоохон арга хэмжээнүүд зохион байгуулав.
- НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооноос засгийн газарт ирүүлсэн “Зөвлөмж”-ийг орон даяар бүх шатанд хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, Иргэний бүртгэл мэдээллийн төвтэй 27, 28 дугаар заалтыг хэрэгжүүлэх ажлыг хамтран судалж, ажилласны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанд оруулж, эхний ээлжинд нэн ядуу гэр бүлийн шинээр төрсөн хүүхдэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгох асуудлыг 2006 оны 6 дугаар сараас туршиж, эхлээд байна.

Боловсрол. БСШУ-ы сайд Австри Улсад айлчлал хийх үеэр Австрийн БСШУ-ы сайд нар хоёр орны боловсролын баримт бичиг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээг үзэглэлээ.

⇒ *Ингэснээр манай улсын дээд боловсролын диплом тус улсад хүлээн зөвшөөрөгдөх юм.*

ЕБС-д 2006-2007 оны хичээлийн жилд хэрэглэх сурах бичгүүдийг баталгаажуулав. Батлагдсан сурах бичгүүдийг нийслэл, орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудад сонголт хийлгэх бэлтгэл ажлыг хангаж байна.

✓ *Ирэх хичээлийн жилд 30 нэрийн сурах бичиг шинээр хэвлэгдэх ба энэ удаагийн сонголтод 37 нэрийн 86 төрлийн сурах бичиг орж байна.*

Ерөнхий боловсролын сургуулийн 11 жилийн сургалтын талаар баримтлах бодлого, ЕБС-д 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөө, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг батлан аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газруудад хүргүүлээ.

⇒ *Шинээр батлагдсан сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон 5 хоногийн сургалтыг 8 хэсгээр зохион байгуулж, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дарга зүйчид 240 гаруй хүнийг хамрууллаа.*

Шинэ журмаар явагдсан ерөнхий шалгалтын дүнг гаргаж, батламжийг сургууль, сурагчдад олгож эхлэсний зэрэгцээ шалгалтын дүнтэй холбоотой иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг тухай бүр авч зохих шийдвэрүүдийг цаг алдалгүй өгөх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Уг ажилтай холбогдуулаад их, дээд сургуулийн элсэлтийн хугацааг сунгахыг сургуулийн удирдлагуудад үүрэг болгоод байна.

ЮНЕСКО-ийн санхүүжилтээр 2004-2006 онд хэрэгжүүлсэн “Боловсрол, соёлын явуулын иж бүрэн үйлчилгээг Монголын малчдад хүргэх нь” төслийн үнэлгээний тайлангийн хурлыг зохион байгууллаа. Уг төслийг 10 аймгийн арван суманд хэрэгжүүлсэн бөгөөд албан бус боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, соёл гэсэн гурван чиглэлийн үйл ажиллагааг амжилттай нэгтгэж, хөдөөгийн малчдад нийгмийн үйлчилгээг үзүүлэх зорилготой юм.

- *Нийгмийн үйлчилгээнээс алслагдсан, ийм төрлийн хэрэгцээг үгүйлж байсан ард түмнийг хамруулсан, малчдын хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох, малчдад соёлын төрөл бүрийн арга хэмжээг хүргэх ажлыг багийн хэмжээнд амжилттай зохион байгуулж чадсанаараа төслийн гол зорилго биелсэн гэж санхүүжүүлэгч байгууллагаас дүгнээд энэ оноос дахин 10 аймагт үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.*

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилтээр “Монголын боловсролын удирдлагын төлөвлөлт, хэрэгжилт” сэдвийн дор зайны сургалтаар тасралтгүй боловсролыг олгох сургалтад нийслэл, орон нутгийн 15 боловсролын байгууллагын албан хаагчдыг мөн тус улсын Солонгос судлалын академитай хамтран хоёр орны ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт хоёр орны түүх, соёл, уламжлал, харилцааны тухай хэрхэн тусгасан талаарх харилцан мэдээлсэн сургалтад БСШУЯ, Боловсролын хүрээлэнгийн ажилтнуудыг тус тус хамрууллаа.

Словакийн Засгийн газар, ADRA олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол” төслийн шугамаар харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургууль, орон нутгийн боловсролын байгууллагуудад аудио студи, дохионы толь бичиг, кирилл фондоор бичигдсэн бичвэрийг яриа болгох программ, дижитал сургалтын хэрэгслийг хүлээлгэн өгч суралцах орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлээ.

Соёл, урлагийн талаар: Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд Австри Улсад Монголын соёлын өдрүүдийг зохион байгууллаа.

⇒ *Морин хуур чуулгын тоглолт, “Чингис хаан ба түүний өв залгамжлагчид”, Урчуудын эвлэлийн хорооны уран бүтээлчдийн “Монголын өнгө” уран зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан нь соёл, урлагийн гадаадад сурталчилгааны томоохон ажил боллоо.*

Булган аймгийн Дашинчилэн сумын Хар бухын балгас, Цогт тайжийн Цагаан байшингийн хамгаалалтын бүсийг батлууллаа.

БНАСАУ-д жил бүр зохиогддог “Хаврын баяр” олон улсын наадамд оролцож, манай уран бүтээлчид 3 алтан цом, 8 мөнгөн цом мөн шилдэг хамтлагийн шагналыг хүртлээ.

БСШУ-ы сайд, Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд нар МУИС-д Санскрит судлалын танхим байгуулах санамж бичигт гарын үсэг зурсан нь эртний соёлын харилцаатай хоёр улсын соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хувь нэмрээ оруулсан ажил боллоо.

“Дүрслэх урлагийн шилдэг бүтээл улсын санд худалдан авах журам”, “Ном, хэвлэлийн шилдэг бүтээл худалдан авах журам”, “Хөгжмийн том хэлбэрийн бүтээлийг улсын санд худалдан авах журам”-ыг баталлаа.

Дорноговь аймгийн Ноён хутагт Данзанравжаагийн музейд хадгалагдаж байгаа Ноён Хутагт Данзанравжаагийн бичсэн зохиолын гар бичмэл болон хэрэглэж байсан эд зүйл зэрэг 7 эд зүйлийг түүх, соёлын хосгүй үнэт, дурсгалт зүйлийн жагсаалтад оруулахаар шийдвэрлэлээ.

Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсийг 121967 га газар байхаар тогтоон, Орхоны хөндийн менежментийн төлөвлөгөөг батлах, хамгаалалтын захиргааны зардлыг 2007 оноос эхлэн төсөвт тусгах асуудлыг шийдвэрлэв.

“Алдагдсан болон гэмтээгдсэн ном хэвлэлийг төлүүлэх журам”-д өөрчлөлт оруулах, “Тэргүүний уншигч - Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах журмыг батлуулсан номын үнэ цэнийг өсгөх, хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх, түүгээр дамжуулан танин мэдэх хүрээг нь тэлэхэд чиглэсэн ажил болсон.

Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой тэмдэглэх арга хэмжээний Төрийн түүхийн музейн үзмэр дэглэж, зохион байгуулахаар анхны үзмэр болох XII, XIII дугаар зууны үеийн Монголын үеийн хаад, хатдын 23 хөрөг зурагны хуулбарыг Тайваны Хааны ордон музейгээс хүлээн авсаны зэрэгцээ улс, аймгийн музей, Эрдэнэсийн сангаас үзмэр

сонгох, зарим үзмэрийг захиалж хийлгэх ажлыг хийж байгаа бөгөөд 2006 оны 7 дугаар 3-ны өдөр Төрийн музейн эхний үзмэрүүдээр үзэсгэлэн зохион байгуулна.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн төлөвлөгөөт ажлын хүрээнд “Төрт ёсны түүх уламжлал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, хуралд ОХУ, Франц, Энэтхэг, ХБНГУ, Япон, БНСУ, БНХАУ зэрэг 10 гаруй орны эрдэмтэд оролцож илтгэл тавилаа. Их Монгол улсын түүх, Монгол төрийн түүх, уламжлал, төрт ёс, Монгол судлалын талаар дэлхийн олон улсад судлагддаг төдийгүй энэ талаарх судалгаа, шинжилгээний ажил, судлаачдын тоо улам нэмэгдэж байгаа талаар хурлыг зохион байгуулагчдын зүгээс дүгнэлээ.

**Эрүүл мэнд.** Эмнэлгийн мэргэжилтнүүдэд олгодог байсан 157 төрлийн лицензийг цөөрүүлэн 4 болгож, түүнийг сард 1 удаа хуралддаг комиссын шийдвэрийг үндэслэн олгодог байсныг болиулж, материал болон кредит нь бүрдсэн тохиолдолд шууд олгож байхаар боллоо.

ЭМЯ-ны “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл”-ийн комисс, “Магадлан итгэмжлэлийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд өмнө нь ороогүй байсан Хувийн хэвшлийн эрүүл мэндийн холбооны төлөөллийг оролцуулах шийдвэр гаргалаа.

Хөдөө, орон нутгийн эмнэлгүүдийг эмчээр хангах асуудлыг судалж санхүүгийн болон эрх зүйн хөшүүргүүдийг хэрэглэхээр Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт орууллаа.

- Анагаах ухааны сургууль төгссөн эмч нар сум, сум дунд, өрхийн эмнэлэгт 2 жилийн хугацаагаар заавал ажиллах боллоо.
- Сум, сум дундын эмнэлэгт 3-аас дээш жил тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг төрийн зардлаар төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамруулах, их эмчид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагаас олгохоор хуульд өөрчлөлт оруулаад байна.
- Эрүүл мэндийн байгууллагад 25 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд тэтгэвэрт гарахад нь 12 сарын, үүнээс сум, тосгон, сум дундын эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд 18 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг зөвхөн эмч, сувилагчид олгож байсныг сумын эмнэлгийн жолооч, асрагч зэрэг бусад ажилтнуудад мөн хамруулахаар хуульд өөрчлөлт хийсэн.

Баянхонгор аймгийн Жаргалант, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Говь-Алтай аймгийн Бигэр сум, суурингийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор дээрх сумын эмнэлгийг сум дундын эмнэлэг болгов.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг болон шинжилгээ, оношлогоог дараалал харгалзахгүй хийлгэж байхыг бүх шатны эмнэлгүүдэд үүрэг болгов.

ЭМЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2006 онд хэрэгжүүлэх “Сайн засаглал эрүүл мэндийн салбарт: Ёс зүй, шударга байдлыг хөгжүүлэх нь” төслийн нэгдсэн зохицуулга, удирдлагаар хангах Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, журмыг батлан хэрэгжүүлж байна.

Хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний шуурхай, бэлэн байдлыг хангах, чирэгдэлгүй үйлчилгээг дэмжих зорилгоор “Шуурхай үйлчилгээ-сэтгэл ханамж” сарын аян зохион байгуулав.

Өрхийн эмнэлгийн нэг иргэнээр болон даатгуулагчаар тооцсон санхүүжилтийн хэмжээг батлав.

- Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэг иргэнд жилд 3800 төгрөг (үүнээс: эрүүл мэндийн даатгалын сангаас 2250 төгрөг, улсын төсвөөс 1550 төгрөг), амьжиргааны баталгаажих түвшингээс дээгүүр орлоготой нэг иргэнд жилд 2800 төгрөг (үүнээс: эрүүл мэндийн даатгалын сангаас 1700 төгрөг, улсын төсвөөс 1100 төгрөг) байхаар тогтоов.

“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг батлуулав. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа вируст гепатит, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ДОХ зэрэг халдварт өвчин, зүрх судас, умайн хүзүүний хавдар, чихрийн шижин зэрэг халдварт бус өвчнийг бууруулж, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор өвчлөлийн төвшин тогтоох, үзлэгээр илэрсэн хүмүүсийг эмчилгээнд хамруулах, өвчлөлийн мэдээллийн сан байгуулах, эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа явуулахаар урьдчилан сэргийлэх үзлэгийг 15-аас дээш насны хүн амын дунд хийх гэж байна.

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дүрэм, салбар хороодын үлгэрчилсэн журам, мэс засал/мэс ажилбар хийлгэх тухай зөвшөөрлийн хуудас, амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийн хуудас, өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах зөвшөөрлийн хуудас, тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай хуудсыг батлав.

“Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, “ХДХВ/ДОХ-той тэмцэх, сэргийлэх үндэсний стратегийн шинэчилсэн хувилбарын төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Хамтдаа сэргийлье” ХДХВ/ДОХ-ын асуудлаарх үндэсний семинарыг зохион байгуулав.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Дэлхийн оюутны аварга шалгаруулах бөхийн чөлөөт, сонгомол барилдааны VII тэмцээний үеэр эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зорилгоор 2 эмч томилон, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, яаралтай тусламжийн машин бэлэн байлгаж ажиллалаа.

Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг зохион байгуулж заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 250 гаруй хүүхдийг дархлаажуулсан. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Нийслэлийн хараа хяналтгүй 120 гаруй хүүхдийг эмчийн үзлэгт оруулан дархлаажуулсан.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн “Булигар” ХК-ний ажилчдын дунд гарсан хоолны хордлогот халдварын голомтын халдвар эсэргүүцэх арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж өвчилсөн 67 хүнд тархвар зүйн судалгаа хийж 25 хүнийг Хордлогын яаралтай төв болон ХӨСҮТ-ийн клиникийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн.

*Шуурхай мэдээ.* 2006 оны 6 сарын 22-ны байдлаар Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангамж хотод 95%, хөдөө орон нутагт 70 %-тай байна.

2006 оны эхний 5 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 19119 эх төрснөөс 16 эхийн эндэгдлийн тохиолдол гарсан нь 100000 амьд төрөлтөд 83.6 болж өмнөх оныхоос 1,6 дахин буурсан байна. Улсын хэмжээнд нялхасын эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхэд тутамд 22.6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс буурч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхэд тутамд 27.1 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 2.8 промилээр буурсан байна.

Оны эхний 5 сарын байдлаар халдварт өвчний 15820 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн ам тутамд 61.5 байна. Аймгуудын хувьд авч үзвэл энэ сард Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Өвөрхангай, Төв, Увс, Хэнтий аймгуудад болон Улаанбаатар хотод халдварт өвчин нэмэгдсэн байна.

Энэ оны эхний 5 сарын байдлаар ХДХВ/ДОХ-ын халдвар авсан 5 тохиолдол бүртгэгдээд байна.

## **2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулав.

- *Хуулиар Нягтлан бодох мэргэжлийн зөвлөлийг татан буулгаж, чиг үүргийг нь Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйн хэлтэс, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд хариуцуулж, аудитын компани, аудиторын эрх үүргийг тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүллээ.*

Монгол Улсын Засгийн газар - гадаад түншүүдийн хамтарсан техникийн уулзалтыг Дэлхийн банктай хамтран зохион байгууллаа.

- Уулзалт нь хөгжлийн хамтын ажиллагааны шинэ чиг хандлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, улмаар зээл, тусламжийн бодлогыг үндэсний хөгжлийн стратеги, улсын төсөв болон хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулах анхны чухал алхам боллоо.
- Техникийн уулзалтаар гадаад түншүүдтэй хамтран зээл, тусламжийн шинэ арга хэрэгслийг тохиролцсон явдал чухал ололт боллоо. Энэхүү шинэ арга хэрэгсэл нь эдийн засгийн бодит хөгжлийг дэмжсэн, үр дүнд суурилсан, давхардлыг арилгасан, эргэж тайлагнадаг, ил тод байх зарчимд тулгуурлахад оршино.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банк хооронд байгуулсан “Орон нутгийн зам сайжруулах” төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай, Монгол Улсын Засгийн газар, Шведийн Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн хооронд байгуулсан “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээг шинэчлэн засварлах” төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай хуулийг батлуулав.

Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифын өөрчлөлттэй уялдуулан төрийн албан хаагчийн албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоолоо.

- Аймагт 15500 төгрөгөөр, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 23500 төгрөгөөр, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд зам хоногийн зардлыг аймаг, нийслэлд 6500 төгрөгөөр, аймгийн төвөөс сумдад ажиллах төрийн албан хаагчийн албан томилолтын зам хоногийг зардлыг 4500 төгрөгөөр тогтоолоо.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан 300 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн соёрхон батлуулав.

Монгол Улсын 2005 оны төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын 2005 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн Монгол Улсын 2005 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай УИХ-ын тогтоолыг батлуулсан.

УИХ-ын хаврын чуулганы 6 дугаар сарын нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2006 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, түүнчлэн Хүн амын орлогын албан татварын тухай, Санхүүгийн түрээсийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Онцгой албан татварын тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлж батлууллаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

Улсын төсвийн нэмэлт хөрөнгө оруулалтын тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, улсын төсвийн 2006 оны хөрөнгө оруулалтын хэмжээг **44.8** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад “Буман нарны гэр” хөтөлбөрийн дагуу малчин өрхийг цахилгааны эх үүсвэрээр хангахад 9.2 тэрбум төгрөг, Говь-Алтайн Тайширын усан цахилгаан станцад 3.3 тэрбум төгрөг, Мянганы замын төсөлд 8.9 тэрбум төгрөг, Баянзүрх дүүргийн Дарь-Эхэд баригдах 640 суудалтай сургуулийн барилгад 500,0 сая төгрөг, төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжүүлж байгаатай холбогдуулан Мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн төвд 7,0 тэрбум төгрөг, Иргэний нисэхийн ерөнхий газарт 8.3 тэрбум төгрөгийг тус тус нэмж тусгав.

Монгол Улсын Засгийн газар, Испанийн Вант Улсын Институт дэ Кредито Офисиалын хооронд байгуулсан “Төв цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл”-ийн хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов. Испанийн вангийн нэрэмжит зээлээр 4.7 сая еврогийн хөрөнгө оруулалт хийж, тоног



төхөөрөмжийг шинэчилснээр Төв цэвэрлэх байгууламжийн агаарын бохирдол багасаж, лагийн ялзрах үйл явцад гардаг эвгүй үнэр арилах боломжтой болох юм.

Улаанбаатар хотноо байгуулсан Хүмүүнлэгийн тусламж болон техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон.

- Энэхүү хэлэлцээрийг байгуулснаар хоёр орны хамтын ажиллагаа шинэ шатанд гарч, манай улс тус улсаас жил бүр 2,5-4 сая ам.долларын буцалтгүй тусламжийн төсөл хэрэгжүүлэх боломж нээгдэж байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулах “Санхүүгийн зохицуулалт ба засаглалын хөтөлбөрийн зээлийн хэлэлцээр”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, төслийг зарчмын хувьд дэмжлээ. Азийн хөгжлийн банкнаас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан Монгол Улсын Засгийн газарт 10 сая ам.доллартай тэнцэх салбарын хөгжлийн хөтөлбөрийн зээл, мөн 900 мянган ам.доллартай тэнцэх зөвлөх үйлчилгээний буцалтгүй тусламжийг олгохоор шийдвэрлэсэн. 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх төслийн хүрээнд банкны салбарын эрсдэлийг бууруулах, банк бус санхүүгийн зохицуулагчдын бүтэц, зохион байгуулалт, түүний зохицуулах чадавхийг бэхжүүлэх, улмаар банк бус санхүүгийн салбарын хууль эрхзүйн ба зохицуулалтын хийгдлийг арилгах, сонирхогч талуудын баталгааг сайжруулах, мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх бүтцийг бүрдүүлэх болно. Харин Азийн хөгжлийн банкны Японы тусгай сангаас үзүүлэх зөвлөх үйлчилгээний техникийн туслалцааг Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн албанд дэмжлэг үзүүлэхэд зарцуулна. Монголын эдийн засгийн эрсдэлийг багасгахад энэхүү хөгжлийн хөтөлбөрийн санхүүгийн зээлийг ашиглах бөгөөд төсөвт шууд дэмжлэг үзүүлэх утгаараа урьд өмнөх техникийн зээлээс давуу талтай юм.

Монгол Улсын Сангийн сайдтай Татварын төлөгчдийн уулзалтыг 7 дахь жилдээ зохион байгуулж, түүнд татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын 300 орчим удирдах ажилтныг оролцуулах арга хэмжээ авлаа.

Сангийн сайд тэргүүтэй Монголын төлөөлөгчид АНУ-ын Вашингтон хотноо зохиогдсон ОУВС, Дэлхийн банкны 2006 оны хаврын чуулга улзалтад оролцсон. Монголын талаас Мянганы сорилын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр санал болгосон дөрвөн төслөөс Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах чиглэлийн төслийг Орон сууцны төсөл болгож өөрчлөх тухай саналыг зөвшөөрсөн.

Түлш, эрчим хүчний үйлдвэр, компаниудын хооронд үүсэж олон жил хуримтлагдсан өр, авлагыг багасгах, тэдгээрийн санхүү, хөрөнгийн чадавхийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа, эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор Түлш, эрчим хүчний үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээ тухай Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов.

- Тогтоолоор цахилгаан түгээх болон дулааны сүлжээ компаниудаас дулааны цахилгаан станцуудад төлөх ёстой 2001 оноос өмнө үүссэн эх үүсвэргүй 17.5 тэрбум төгрөгийн өрийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу дансны бичилт хийх замаар Эрчим хүчний үйлдвэрүүдийн хоорондын өр, авлагын сүлжээг арилгах арга хэмжээ авахыг Сангийн сайд, Түлш, эрчим хүчний сайд, Төрийн өмчийн хорооны дарга нарт зөвшөөрсөн байна.
- Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдэд зээл, тусламжаар хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй төслийн зээлийн дамжуулан зээлдүүлэх гэрээний зээлийн хүү ба төлөх хугацааг гадаад орон, олон улсын байгууллагуудтай байгуулсан үндсэн гэрээний хүүгийн түвшин, зээл төлөх хугацаанд ойртуулах чиглэлээр өөрчлөлт оруулан шинэчилж мөрдүүлэх; Эгийн голын усан цахилгаан станц барих төслийн судалгаа явуулах, зураг төсөл боловсруулах зориулалтаар Азийн хөгжлийн банкнаас авсан зээлийн дамжуулан зээлдэх гэрээнд тусгасан зээл ба хүүгийн төлбөрийг усан цахилгаан станц баригдаж ашиглалтад орох хүртэл хойшлуулах; ОХУ-аас импортоор авдаг эрчим хүчний чадлын захиалгад төлж буй төлбөрт гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж байгааг

хянан үзэж зохицуулах арга хэмжээ авах; төсөвт байгууллагуудын 2006 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар эрчим хүчний үйлдвэрүүдэд төлөх ёстой цахилгаан, дулааны эрчим хүчний өр 928.4 сая төгрөгийг 2006 оны эхний хагас жилд багтаан төлж барагдуулах; Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн цахилгаан түгээх сүлжээ компаниудад тухайн аймгуудын төрийн сангаас 2003, 2004 онд зээл хэлбэрээр олгосон боловч өнөөг хүртэл эргүүлэн төлж чадахгүй байгаа 412.0 сая төгрөгийг 10 жилд багтааж төлүүлэхээр холбогдох “Цахилгаан түгээх сүлжээ” компаниудтай төлбөрийн гэрээ байгуулах, өр авлага үүсэхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэхийг Сангийн сайд, Түлш эрчим хүчний сайд, Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.

Мянганы хөгжлийн зорилтот суурилсан үндэсний хөгжлийн стратеги боловсруулах ажлын хүрээнд Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэрэгцээг тооцох ажил дуусаж, одоо энэхүү тооцоог нягтлан шалгах, нэгтгэх ажлыг хийж байна. Макро эдийн засгийн загварын хувьд НҮБ-ын захиалгаар ДСИ (DSI-Decision Support International) байгууллагын боловсруулсан “Ерөнхийлсөн макро эдийн засгийн хүрээ” (GMF-Generalized Macroeconomic Framework) загварыг ашиглахаар тохиролцсон.

Монгол Улсын 2006 оны төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан Төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарийг шинэчлэн баталж, төсвийн байгууллагын төлөвлөгөө, хуваарийн задаргааг FISCAL програмд оруулж, байгууллага бүрийн төсвийн хуваарийг FreeBalance програмд хөрвүүлэв.

Улсын нэгдсэн төсөвт оны эхний 5 сард нийт 332,4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 409,1 тэрбум төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 23,1 хувиар давуулан биелүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 137,6 тэрбум төгрөгөөр буюу 50 хувиар илүү байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага 316,6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 46.8 тэрбум төгрөгөөр буюу 17.3 хувиар өсчээ. Хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) 22,8 тэрбум төгрөгт хүрч, 58,0 хувийн, түүнчлэн дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт 20,6 тэрбум төгрөгт хүрч, 55,6 хувийн тус тус гүйцэтгэлтэй гарсан. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13,4 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү хийгдсэн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл (өссөн дүнгээр) **121,1** тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл **92,5** тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Эрүүл мэндийн салбарын аймаг, нийслэлийн 95 төсөвт байгууллагын он дамжин хуримтлагдсан нийтдээ 328,622.2 мянган төгрөг (эмийн өр 252,347.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өр 37,958.5 мянган төгрөг, алсын дуудлагын машины шатахууны өр 38,316.5 мянган төгрөг)-ийг Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээс зөвхөн өр барагдуулах зориулалтаар зарцуулж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, төсвийн өр авлага үүсгэхгүй байх, төсвийн сахилгыг чанд сахиж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгалаа.

Засгийн газар 2006 оны эхний 6 сард (өссөн дүнгээр) гадаад зээлийн үндсэн төлбөрт 14.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 7.5 тэрбум төгрөг, нийт **21.5** тэрбум төгрөг төлж, Засгийн газрын бондын үндсэн төлбөрт 3.9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 243,6 сая төгрөг, бүгд **4.14** тэрбум төгрөг төлсөн.

**Үйлдвэрлэл, худалдаа.** Оёмол, сүлжмэл эдлэлийн үйлдвэрийн нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас нөхөн олгох журмыг батлан, мөрдүүлэв.

- Журмаар ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын төлбөрийн нөхөн олговрын хэмжээг 3-5 жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан бол 40 хувь, 5-аас дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан бол 50 хувь байхаар тогтоолоо.

“Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хууль батлагдан, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

ОХУ-ын хөрөнгө оруулалттай “Алтан Дорнод Монгол” ХХК-ийн алтны шороон орд руу гар аргаар алт олборлогчид дайрч, олборлохоор бэлтгэсэн шороон ордыг ашигласнаас ихээхэн хэмжээний хохирол учруулсан гэж үзэж манай Засгийн газраас нэхэмжилсэн 3,7 тэрбэм төгрөгийн асуудлыг ярилцаж хүчингүй болгохоор шийдвэрлэв.

Монгол-АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн II хуралдаан болж, АНУ-ын Төрийн департамент, Худалдааны яам, Худалдаа хөгжлийн агентлаг, Экспорт-Импортын банк, Дэлхийн банк зэрэг байгууллагын хүмүүстэй уулзалт хийж, худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар санал солилцов.

Канадын Торонто хотноо болсон уул уурхайн салбарын олон улсын чуулга уулзалтад ҮХ-ны сайд оролцон, манай улсын эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол, гадаадын хөрөнгө оруулалтын орчин, хамтын ажиллагааны байдал, цаашдын чиг хандлагын талаар үг хэлэв.

ҮХЯ, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн төлөөлөгчид Далянь хотод очиж хөрөнгө оруулагчаар шалгарсан Вест Прадаиз компанийн удирдлагатай хэлэлцээ хийж, Чөлөөт бүс байгуулах ажлыг эхлүүлэх, хөрөнгө оруулалтыг түргэтгэх асуудлаар тохиролцоонд хүрлээ.

БНХАУ-ын Тайван Улсад ажлын айлчлал хийж, Тайванийн Эдийн засгийн яамны гадаад худалдааны товчоо, ЖДҮ-ийн газар, Аж үйлдвэрийн хөгжил, хөрөнгө оруулалтын төв болон Тайванийн Гадаад худалдааг хөгжүүлэх зөвлөлийн холбогдох албаны хүмүүстэй уулзаж, Монгол Улсын үйлдвэр, худалдааны салбарын хүрээнд хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов.

Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон баталсан.

- *Хоёр үе шаттай зээлийг Худалдаа, хөгжлийн банк, Зоос банк, ХАА-н банк, Хас банк, Капитрон банк зэрэг арилжааны банкаар дамжуулан аж ахуйн нэгжид жилийн 6-7 хувийн хүүтэй олгохоор тооцож байна. Японы Засгийн газраас **25,963.0** мянган ам. долларын хөнгөлөлттэй зээлийг манай улсад жилийн 0.75 хувийн хүүтэй, 40 жилийн хугацаатайгаар олгож байгаа бөгөөд эхний 10 жилд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх ерөнхий нөхцөлтэй юм.*

Дэлхийн гаалийн байгууллагын суурь конвенц болох Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенцид Монгол Улс нэгдэн орох тухай хуулийг баталсан. Дэлхийн гаалийн байгууллагаас энэхүү конвенцийг Киото хотноо баталсан бөгөөд дэлхийн 44 орон гишүүнээр нэгдсэн байна.

- *Манай улс энэхүү конвенцэд нэгдэн орсноор олон улсын жишигт хүрсэн гаалийн бүрдүүлэлтийн горимтой болох үндэс суурь тавигдах, эрхзүйн орчин улам боловсронгуй болох боломжтой юм.*
- *Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой маргаан, хүндрэл үүссэн тохиолдолд олон улсын эрхзүйн баримт бичгийг баримтлах төдийгүй хууль ёсоор гадаад худалдааны бизнес эрхлэгчид гаалийн хялбарчилсан бүрдүүлэлтэд хамрагдах таатай боломж бүрдэх болно. Цахим гааль, гаалийн бүрдүүлэлтийн цаасгүй горим үүсэх эхлэл тавигдаж, гаалийн үйлчилгээний соёл, шуурхай байдал нэмэгдэнэ.*

Дарханы дулааны цахилгаан станц ХК-ийн хэрэгжүүлж буй “Турбогенераторыг шинэчлэх төсөл”-ийн нэмэлт хөрөнгийн тухай Засгийн хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт нэмэлт оруулах талаар ажиллахаар болов. Хэлэлцээрийн дагуу Дарханы дулааны цахилгаан станцын тоноглолын шинэчлэлийн төсөлд нийтдээ 10.0 сая еврогийн санхүүжилт шаардлагатай гэж тооцож, үүний 8.0 сая еврог ХБНГУ-ын Сэргээн босголтын KfW банкны хөнгөлөлттэй зээлээр, 2.0 сая еврог Монголын талын хөрөнгөөр санхүүжүүлэхээр тохиролцсон ч судалгаагаар төсөлд нийтдээ 16.0 сая евро шаардлагатай

гэсэн тооцоо гарч, нэмэлт 2.5 сая еврог Германы тал санхүүгийн хамтын ажиллагааны сангаас санхүүжүүлж болох юм гэсэн саналыг тавьсан.

“Тайширын усан цахилгаан станц” төслийн тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Монголын талаас санхүүжүүлэх 2,75 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө гаргахаар тогтов.

Монгол Улсын Засгийн газар, Испанийн Вант Улсын Засгийн газар хооронд байгуулах Дулааны үр ашгийн төслийн Зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн зарчмын хувьд дэмжиж, УИХ-ын холбогдох байнгын хороодтой зөвшилцөх нь зүйтэй гэж үзэв.

- *Испаний Засгийн газраас санхүүжүүлэх III, IV цахилгаан станцын дулаан хангамжийн чиглэлээр авах энэ удаагийн зээлээр хэрэгжүүлэх III багц ажил нь Улаанбаатар Дулааны станц ХК-ийн эзэмшлийн хувьсах хурдны 10 насос суурилуулах, Орон сууц, нийтийн аж ахуйн газрын харъяа конторуудын 27.4 км урт хуучирч нэвтрүүлэх чадвар муудсан түгээлтийн шугамыг өргөсгөн шинэчлэх юм. Багц ажлыг гүйцэтгэсний дүнд дулааны эрчим хүчийг хэмнэлттэй зарцуулах үндсэн нөхцөл бүрдэж, тоо ба чанарын үзүүлэлт хосолсон тохируулгад шилжиж, технологийн горим шинэчлэгдэх болно.*

Атомын цахилгаан эрчим хүчний салбарт тэргүүлэгч Францын Areva групп Монгол Улсад айлчилж, Монгол Улсын Ерөнхий сайд, ҮХ-ний сайд болон бусад хүмүүстэй уулзаж, Монгол Улсад цацраг идэвхт бодисоос хамгаалах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой гэдгээ мэдэгдэн, хамтран ажиллах Санамж бичиг байгуулав.

Үйлдвэр худалдааны сайд Б.Жаргалсайхан тэргүүтэй төлөөлөгчид БНТУ-д албан ёсны айлчлал хийж, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, зарим тодорхой төсөл хэрэгжүүлэх талаар ярилцав.

- *“Алтанбулаг” ХЧБ-ийн захиргаа, БНТУ-ын гадаад худалдааны хорооны Чөлөөт бүсийн ерөнхий захиргаатай хамтран ажиллах Протокол байгуулав.*

Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Нэг цэгийн үйлчилгээ”-г туршилтын журмаар УБ хотын Сүхбаатар дүүрэг, Дархан хотод хэрэгжүүлэхээр төсөл боловсруулав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэж байгаатай холбоотой Стратегийн ач холбогдолтой нэр бүхий томоохон ордуудын жагсаалтыг гаргав.

Лизингийн тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж байна.

“Армоно” корпорацийн Ой, модны эрдэм судлалын төвийг ШУТИС-д шилжүүлэх асуудлаар УИХ-ын 48 дугаар тогтоолд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэв.

“Геологийн салбарт төрөөс баримтлах бодлого”-ын төслийг боловсруулаад байна.

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Пиротехникийн хэрэгслийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн төслийг эцэслэн боловсруулав.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ, УИХ-ын ЭЗБХ-оор хэлэлцүүлж байна. Ашигт малтмалын үнийн гэнэтийн ашгийн татварын тухай хууль батлагдсантай холбогдуулан “Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулав.

ҮХ-ий сайд тэргүүтэй төлөөлөгчид Итали Улсад айлчлав. Италийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүн хөрөнгө оруулагчдын зөвлөлд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, хөнгөн үйлдвэрийг сэргээн хөгжүүлэх төсөл, арьс шир, ноос ноолуурын салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх, 3 дахь зах зээлд хамтран ажиллах зэрэг асуудлаар санал солилцов.

ҮХЯ, Японы Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яам хооронд I зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан ба уулзалтаас Санамж бичиг гаргахаар тохиролцож, гарын үсэг зурав.

### 3. БАЙГАЛЬ ОРЧИН

Ховд, Баян-Өлгий аймгийн зааг нутаг дахь Мөнххайрхан уул, Архангай, Өвөрхангай аймгийн зааг нутаг дахь Орхоны хөндийг **байгалийн цогцолбор** газрын ангиллаар, Увс аймгийн нутаг дахь Тэсийн голын сав нутгийг **байгалийн нөөц** газрын, Хөвсгөл аймгийн нутаг дахь Даян дээрхийн орчмын газрыг **дурсгалт газрын** ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авах тухай асуудлыг боловсруулан УИХ-аар батлуулав. Энэ 4 хэсэг 520.0 мянган га нутгийг улсын тусгай хамгаалалтад авснаар Монгол улсын бүх нутаг дэвсгэрийн 13.7 хувь буюу 21.5 сая га нутаг тусгай хамгаалалттай нутгийн сүлжээнд оров.

“Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулав.

- *Хуулиар үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг 20-30 төгрөг байсныг 700-1000 төгрөг, ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрлийн хураамжийн нэг удаагийн эрхийн бичигт 400-600 төгрөг байсныг 8000-10000 төгрөг байхаар тогтоосон нь орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, загас, шувуу хамгаалах эдийн засгийн үндэс бэхжих, эрх зүйн орчин боловсронгуй болох, экологийн тэнцвэр хадгалагдах зэрэг байгаль хамгаалалын ач холбогдолтой юм.*

Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-аар батлууллаа.

Байгаль хамгаалагчдын хариуцах талбайн норматив шинэчлэгдсэнтэй уялдуулан Монгол Улсын бүх сумын бүсийн ангиллын жагсаалтыг шинэчлэн боловсруулж батлуулав.

Увс аймгийн Тэс сумын Тэсийн голын сав нутгийн байгалийн нөөц газрын болон Хөвсгөл аймгийн Цагаан-үүр сумын Даян Дээрхийн байгалийн дурсгалт газрын хилийн заагыг тогтоох тухай Засгийн газрын тогтоолыг гаргав.

Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах байгаль хамгаалагчдын хариуцах талбайн нормативыг шинэчлэн батлав.

Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөрийг батлав.

Дорноговь аймагт хур тунадас нэмэгдүүлэх талаар нутгийн иргэдээс Ерөнхий сайдад санал тавьсны дагуу хур тунадас нэмэгдүүлэх ажлын хөрөнгийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс 25 сая төгрөг гаргахаар шийдвэрлэв. Үүний дүнд Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгийн нутгаар үүлэнд зориудаар үйлчилж тунадас нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажлын 3 хэсгийг ажиллуулж байна.

Гол мөрний сав газрын зөвлөлийн дүрэм, усны тоо бүртгэлийн журам, усны мэдээллийн сан болон улсын усны кадастрыг бүрдүүлэх, үзүүлэлт хөтлөх, Ус ашиглуулах тухай мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвшөөрөл олгох, усны нөөцийн ашиглалтанд хяналт тавих журмуудыг батлав.

Ой, хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах энэ талын мэдээлэлийг сайжруулах зорилгоор хариуцлагатай жижүүр ажиллуулан, түймрийн цагийн байдлын мэдээг танилцуулж байна. 4 дүгээр сарын 10-наас 6-р сарын 15-ны хооронд 67 хүн жижүүр хийж, энэ хугацаанд 98 удаа түймэр гарч орон нутагт түймрийг унтраах ажлыг зохион байгуулсан.

2006 онд Байгалийн ургамал ойн дагалт баялаг түүж ашиглах дээд хязгаарыг тогтоох тушаалыг гаргав.

Нэн ховор мазаалай баавгайн нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх үйл ажиллагааны төслийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангах ажлыг Монголын ховор амьтдыг хамгаалах Үндэсний Комиссоор дамжуулан зохион байгуулж эхэллээ.

Дорноговь, Өмнөговь аймгийн хил залгаа нутаг болох Модон шанд хэмээх газарт хууль бусаар алт олборлож, алтны илэрц бүхий чулуу, шороо зөөх, тээрэмдэх зэрэг

үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажиллагааг хангах зорилгоор “Хэв журам-4” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.

2006 онд улсын төсөвт тусгагдсан Ойн хөнөөлт шавж өвчинтэй тэмцэх ажил болон ой зохион байгуулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ойн хортонтой тэмцэх ажлыг эхэллээ.

Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц төлөвлөгөөт даалгавраас 2-10 хувиар дээгүүр байлаа. Тухайлбал: 3 дугаар сарын 8-9, 15-16, 23-24 болон 4 дүгээр сарын 6-7, 9-10, 21-22-ны өдрүүдэд болсон цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс ард иргэдийг 2 хоногийн өмнөөс урьдчилан сэрэмжлүүлэх арга хэмжээ авч чадав.

Байгаль орчны бодлого үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг 5 дугаар сарын 19-21 өдрүүдэд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Байгаль орчны яамны газар хэлтэс, харьяа газар, олон улсын төсөл, хөтөлбөр, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Эко-Ази дээд сургууль, залуу байгальч хөдөлгөөний идэвхтэн дэмжигч 120 гаруй хүн, 16 аж ахуйн нэгж 70 гаруй самбар үзүүлэн байрлуулан ажиллалаа. Өдөрлөгийн үеэр давхардсан тоогоор 10000 хүнд 25000 орчим танилцуулга тараах материал олгосны дээр 600 орчим хүнээс судалгаа авлаа. Аж ахуйн нэгж байгууллагаас 842 ширхэг тарьц суулгац, 144 кг олон наст болон таримал ургамлын үр борлуулж 4500 ширхэг үхрийн нүдний модны захиалга авсан байна.

Олон улсын хил дамнасан Дагуурын тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах гурван талт гэрээний дагуу ОХУ-ын Чита хотод зохион байгуулагдсан Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын байгаль орчныг хамгаалах төрийн захиргааны байгууллагын төлөөлөгчдийн ээлжит IV хуралдаан, НҮБ-ийн Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос зохион байгуулсан “Зүүн Хойд Ази дахь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа” сэдэвт уулзалт, Турк Улсын Анталия хотноо болсон “Европ болон хойд Ази дахь ойн тухай хуулийн хэрэгжилт, засаглал” хурал, ХБНГУ-ын Бонн хотноо зохион байгуулагдсан “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн хэрэгжүүлэгч байгууллагын ээлжит хуралдаан, Швейцар Улсын Женев хотноо зохион байгуулагдсан “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокольмын конвенцийн талуудын хуралдаан, АНУ-ын Нью Йорк хотноо болсон Тогтвортой хөгжлийн комиссын 14-р хурал зэрэгт оролцлоо.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, БНСУ-ын Хөдөө аж ахуй, ойн сайд Пак хөн Сү-тэй хамтарсан уулзалт хийж “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн анхан шатны төлөвлөгөөг 7-р сард Солонгос Улсын Таэжон хотноо зохион байгуулагдах Ойн хамтарсан хорооны 4 дэх удаагийн хуралдаанаар хэлэлцэхээр тохиролцлоо.

#### **4. ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГО**

“Хот суурины гудамж, зам төлөвлөлт” БНБД-32-04-04–ийг боловсруулаад байна.

- *Тухайн нормоор иргэдийн эрүүл аж төрөхөд чухал шаардлагатай явган хүний гүйлтийн болон унадаг дугуйн зам, нээлттэй орон зай, талбай, ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн зайлшгүй элемент болгож, уг талбайд шаардагдах газрыг өөр зориулалтаар ашиглуулахаар олгохыг хязгаарлаж, хот суурин газрын авто зам, гудамж, талбайн тохижилтод иргэдийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэх юм.*

Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын бүтэц, үзэл баримтлалын төслийг боловсруулж, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдээс санал аван хуулийн төслийг боловсрууллаа.

Бүсийн тулгуур төв хотуудад улсын зэрэглэл олгох асуудлаар УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах үзэл баримтлал болон тогтоолын төсөл, Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулаад байна.

Эхний ээлжинд нэгтгэх бололцоотой аймгийн төвөөс 50 км хүртэл зайтай, хүн ам, газар нутаг багатай зарим сумд болон хоёрдахь ээлжинд өөр хоорондоо 10-50 км зайтай,

хүн ам, газар нутаг багатай, нэгтгэх бололцоотой зарим жижиг сумдын жагсаалтыг тайлбарын хамт гаргаад байна.

Газрын тухай /шинэчилсэн найруулга/ болон Монгол Улсын эрхийн бичгээр газар өмчлүүлэх тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулав.

40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд 4, 40, 80 айлын орон сууцны зураг төслийг ОСҮТ-тэй хамтран шалгаруулж, шалгарсан “Голомт-Өргөө” ХХК-тай гэрээ байгуулж, ажлын зураг төслийг эхлүүлээд байна.

“Улаанбаатар хотын мастер төлөвлөгөөг шинэчлэх, Улаанбаатар болон бусад томоохон хотуудын орон зайн мэдээллийн санг бүрдүүлэх”, “Монгол орны малчин өрх бүрийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээр хангах” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх талаар Япон Улсын Засгийн газар, Дэд бүтцийн яамтай хамтран ажиллахаар тохиролцов.

2005 оноос өмнө нийслэлээс гадна 4 аймаг энэ төлөвлөгөөг батлуулан мөрдөж байсан бол 2006 онд Баянхонгороос бусад бүх аймаг төлөвлөгөөтэй болсон байна.

- Энэ төлөвлөгөөний хүрээнд аймгийн нийт газар нутгийн нөхцөл, нөөцийн мэдээлэл, газар ашиглалтын тоон мэдээлэл бий болсноор орон нутагт газрын мэдээллийн сангийн суурь тавигдлаа.

Залуу гэр бүл, бага, дунд орлоготой өрхөд зориулсан нэг маягийн орон сууцны барилгын загвар төсөл сонгон шалгаруулах уралдааныг зохион байгуулав. Орон сууц хөгжүүлэх сангаас төрийн албан хаагчдад зээл олгох шалгуур үзүүлэлтийг батлуулав.

Ногоон нуур орчмын болон Хүүхдийн урлан бүтээх төвийн арын гэр хороололд орон сууц барихаар боллоо.

- Нийслэлийн хувьд энэ орчмын гэр хороололд агаарын бохирдолт хамгийн их хувь нэмэр оруулдаг байна. Хот төлөвлөлтийн бодлоготой уялдсан ажлыг авч хэрэгжүүлэхээр БХБЯ, Хотын захирагчийн хамтарсан ажлын хэсгийг байгуулав.

Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг “Барилгад чанараар өрсөлдье” Нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг “Ундны усны чанар, хүртээмжийг сайжруулах нь” сэдвээр зохион байгууллаа.

БНСУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд БНСУ-ын Барилга, тээврийн яамны сайд, Монгол Улсын БХБ-ын сайдтай хэлэлцээ хийж, хоёр орны яамд хооронд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

БНСУ-ын Газрын корпораци, Монгол Улсын БХБЯ-ны дэргэдэх Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төвийн хооронд, Солонгосын Орон сууцны үндэсний корпораци, манай Орон сууцны үндэсний төвийн хооронд, Солонгосын Газрын корпораци, манай Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын хооронд тус тус хамтран ажиллах санамж бичгүүдэд гарын үсэг зурлаа.

Японы Засгийн газрын Хамтын ажиллагааны нийгэмлэг (JICA)-ийн техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийх төслийн бичиг баримт болон холбогдох материалыг JICA-аас ирсэн шинжээчдийн багтай эцсийн байдлаар сайжруулан боловсруулахаар хамтран ажиллаж байна.

АХБ-ны техникийн туслалцаатайгаар хэрэгжүүлж буй “Хот байгуулалт, орон сууц”-ны төсөлд хамрагдах аймаг, хотуудын Засаг дарга нарыг АХБ-ны Зүүн болон Төв Азийн газрын хот байгуулалтын мэргэжилтэн хатагтай Эри Хонда тэргүүтэй зээлийн судалгааны ажлын хэсэгтэй 3 талын уулзалтуудыг зохион байгуулан, төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлэлцэн тохиролцов.

**Зам тээвэр.** Монгол Улсын болон Улаанбаатар хотын зам тээвэр, аялал жуулчлал, шуудангийн үйлчилгээг харилцан уялдаа, зохицуулалттайгаар хөгжүүлэх, үйлчилгээний соёл чанарыг сайжруулах талаар ажиллах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, төлөвлөгөө гаргалаа.

Монгол-Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц модны боомтоос Тавантолгойн нүүрсний уурхай хүртэлх 257 км, Шивээ хүрэн-Сэхээгийн боомтоос Нарийн сухайтын нүүрсний уурхай хүртэлх 58,8 км, Баянхошуу-Өвдөгийн боомтоос Монгол Улсын Тамсагийн газрын тосны орд хүртэлх 225 км авто замын маршрутыг тогтоон баталлаа.

Импортоор оруулж ирэх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан 24 ба түүнээс дээш суудалтай, 48 ба түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, үйлдвэрлэснээс хойш 5 хүртэл жилийн доторх автобус, троллейбусанд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулахгүй байх тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

Герман Улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл, тусламжаар хэрэгжих “Бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд авто замын салбарт авах зээлийн гэрээг УИХ-аар соёрхон батлуулав.

Япон Улсын буцалтгүй тусламжийн хүрээнд баригдах Багануур-Хэрлэнгийн гүүр чиглэлийн авто замын барих гэрээнд гарын үсэг зурлаа.

Хархорин-Цэцэрлэгийн чиглэлийн хэсэгчилсэн 46 км замын барилгын ажлын хугацааг 2 жил болгох, зээлийн хуваарилагдаагүй хөрөнгөөр дээрх чиглэлийн замын эхний 40 км замыг хатуу хучилттай болгоход тавигдах нөхцөл, шаардлагыг багасгах талаар Дэлхийн банкны бүс нутгийн менежертэй зөвшилцөн, санамж бичиг гаргалаа.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлтийг хийж Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх олон улсын нислэгийн тоог 50000 хүргэж, орлогыг 8.5-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх зорилтын хүрээнд БНХАУ-ын Бээжингийн чиглэлд гүйцэтгэх нислэгийн давтамж 6 байсныг 8 болгон нэмэгдүүлж, үндэсний агаарын тээвэрлэгчид Бээжин, Хөх хот руу тогтмол нислэг үйлддэг эрхтэй байсныг Шанхай, Урумчи, Тянжин, Хайлаар, Харбинд тогтмол нислэг үйлдэж болохоор эдгээр цэгүүдийг нэмж Хятадын талтай тохиролцов.

Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор тодорхой чиглэлийн авто замуудын тэмдэжүүлэлтийг сайжруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж байна.

БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээр, түүнийг хэрэгжүүлэх тухай протокол, нарийвчилсан журмыг үндэслэн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын эдийн засгийн чөлөөт бүсэд улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах, тээвэрлэлтийн хяналт, зохицуулалтыг сайжруулах зорилгоор Замын-Үүд – Эрээний чиглэлийн улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн байнгын үйлчилгээг Тээврийн үйлчилгээний төвийн Замын-Үүд дэх улс хоорондын авто вокзалын харьяанд эрхлэн зохион байгуулах асуудлыг шийдвэрлэв.

ОХУ-ын Москва хотноо Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын V хурал болж, иргэний нисэхийн салбарт агаарын харилцааг өргөжүүлэх хүрээнд хэд хэдэн агаарын зам нээх асуудал дээр үргэлжлүүлэн ажиллахаар тохирч, хамтын ажиллагааны механизмаа тодорхойллоо.

Газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай” 1969 оны конвенцийг шинэчлэх Протоколыг соёрхон батлуулав.

“Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын дагуу усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж улсын дугаар болон бүртгэлийн гэрчилгээг олгож байна.

“Ан-2” онгоцны паркийн нислэг үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа, техникийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай шатахууны нөөцийг бий болгох хөрөнгийн эх үүсвэр байхгүй байдлыг харгалзан тус газрын 2 ш агаарын хөлгийн их засварын хөрөнгийг шийдвэрлэх, шатахууныг худалдан авч эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр “МИАТ Агросервис” ТӨҮҮГ-ын хэрэгцээнд өгч байх арга хэмжээ авах чиглэлийг ИНЕГ-т өгөв.

✓ Энэхүү арга хэмжээний үр дүнд шинээр байгуулагдаад байгаа “МИАТ Агросервис” ТӨҮҮГ-ын үйл ажиллагаа тогтворжин, цаашид амжилттай хувьчлахад дөхөм болно.



Индонезийн Жакарта хотноо болсон НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн Комисс (АНДЭЗНК)-ын 62 дугаар чуулганд ЗТАЖ-ын сайд Ц.Цэнгэл оролцов. Хуралдаанаар БНСУ-ын Пусан хотноо болох тээврийн асуудал эрхэлсэн сайд нарын уулзалтаар Транс Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах чиглэлээр ажиллахаар шийдвэрлэв.

ЗТАЖ-ын сайд Ц.Цэнгэл ОХУ-ын Москва хотноо айлчлан, ОХУ-ын Тээврийн сайд И.Е.Левитинтэй уулзаж хоёр орны зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцлоо. Тухайлбал, оросын талаас монголын төмөр замд хөрөнгө оруулах боломж, хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэгийг байгуулах тухай 1949 оны Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэх, Монгол-Оросын ЗГХК-ын Тээврийн ажлын хэсгийг ойрын хугацаанд хуралдуулах зэрэг асуудлуудыг авч хэлэлцэв.

“Газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай” 1969 оны конвенцийг шинэчлэх Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна.

Засгийн газрын хуралдаанаар “Дэлхийн шуудан холбооны Дүрмийн VII нэмэлт протокол”-ыг соёрхон батлуулав. Конвенцийн өөрчлөлтөд шуудангийн салбарын тогтвортой хөгжлийг хангах, үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг заалтууд тусгагдсан.

“Шуудангийн санхүүгийн үйлчилгээний хэлэлцээр”-ийг УИХ-аар хэлэлцүүлэн, хэлэлцээрт нэгдэн орсон тухай Монгол Улсын хуулийг соёрхон батлуулсан.

- *Хэлэлцээрт нэгдэн орсноор улс хооронд мөнгөн гуйвуулгын үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх боломж бүрдэж байна.*

“Марк, үнэт цаас үйлдвэрлэх, борлуулах журам”-ыг батлуулав. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан “Чингис хааны үеийн зоос” нэртэй маркийг хэвлүүлэн гүйлгээнд гаргалаа.

Аялал жуулчлал. “Шинэ оны анхны нар харах аялал” зохион байгууллаа. Арга хэмжээнд 500 гаруй жуулчид оролцсоноос 120 нь гадаадын жуулчид байв.

Өвлийн болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Адал явдалт спорт аяллын холбоотой хамтран “Цэвэр цас-цэнгэг агаар” өвлийн спорт аяллыг Богдхан уул, Хэнтийн нуруу-Хагийн хар нуур чиглэл; Хөвсгөл нуурын эрэг дээр “Мөсний баяр” арга хэмжээ зохиогдлоо. Энэхүү арга хэмжээнд гадаадын 30 гаруй жуулчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, дотоодын 800 орчим жуулчид оролцов.

Монгол үндэсний тоглоом наадгайг дэлхий дахинд сурталчлах, таниулах зорилгоор Монгол-наадгай шагайн наадам арга хэмжээг Оюун ухааны олон улсын музейд зохион байгууллаа.

“Говийн өглөө-Тэмээний баяр”, мөн “Сарлагийн баяр” арга хэмжээг зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд 100 гаруй тамирчид оролцсон бөгөөд сүү, цагаан идээний үзэсгэлэн, гар урлалын зүйлсийн худалдаа болж, “Сарлагийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох нь” зөвлөгөөн зохион байгууллаа.

Берлин хотноо болсон “ITB-2006” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд 180 орны 10400 байгууллага оролцож, 7000 гаруй сэтгүүлчид сурвалжиллаа. Манай улсын аялал жуулчлалын компаниуд оролцлоо.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохиогдох “Чингис хаан 800 зуун жилийн тэртээгээс эргэн ирсэн нь” арга хэмжээг зохион байгуулах хамтын ажиллагааны гэрээнд Японы “HIS” компанийн ерөнхийлөгч Савада, ЗТАЖ-ын сайд Ц.Цэнгэл нар гарын үсэг зурав.

Үндэсний аяллын хөтөч-тайлбарлагчийн ангилал зэрэглэл тогтоох шалгалтыг зохион байгууллаа.

“Хятадын жуулчдыг Монгол Улсад бүлгээр аялахыг хөнгөвчлөн дэмжих тухай” Монгол Улсын ЗТАЖЯ, БНХАУ-ын Үндэсний аялал жуулчлалын газар хоорондын харилцан ойлголцох санамж бичгийн дагуу Хятадын жуулчдыг Монгол Улсад бүлгээр аялахыг

дэмжих, хоёр орны ард түмний нөхөрлөлийг бататгах үүднээс Хятад Монголын хилийн аялал жуулчлалыг дэмжих уулзалтыг БНХАУ-ын Эрээн хотноо зохион байгууллаа.

- Уулзалтын үр дүнд ГХЯ-ны Консулын газраас Хятадын жуулчдад бүлгээр аялах виз олгох эрхийг нээснээ албан ёсоор мэдэгдсэн болно.
- Хятад-Монголын компаниуд хооронд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд Хятадын бүлэг жуулчдын эхний бүлэг 5 дугаар сарын 20-ны өдөр Монголд ирсэн.

Булган аймгийн Тэшиг сумын нутаг дахь Бага Илэнх-Айнекийн боомтыг цаашид байнгын ажиллагаатай болгох талаар Бурятын талтай санал солилцон протокол үйлдэв.

БНСУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Монгол Улсад айлчилсан Барилга, тээврийн сайд Чү Бён Жиктэй сайд Ц.Цэнгэл нар БНСУ-ын Барилга, тээврийн яам, Монгол Улсын ЗТАЖЯ хооронд хамтран ажиллах тухай Санамж бичигт гарын үсэг зурав.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Франческо Франжиалли Монгол Улсад айлчлав.

- Дэлхийн аялал жуулчлалын байгууллага ЗТАЖЯ-ны хооронд Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтран ажиллах харилцан ойлголцын санамж байгуулсан.
- Санамж бичигт Монголын аялал жуулчлалын боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, гадаад сурталчилгааг хөгжүүлэх, олон улсын хурал зөвлөгөөнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, Зүүн бүсэд аялал жуулчлал хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх асуудлууд тусгагдсан.

БНСУ-ын Сөүл хотноо жил бүр зохиогддог KOFTA олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 4 компани оролцлоо.

- Үзэсгэлэнд 49 орон оролцсон бөгөөд нийт 75740 хүн үзэж сонирхож, 87 хэвлэл мэдээллийн компани сурталчилсан. Энэ үеэр Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээ болон аялал жуулчлалын чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын баримталж буй бодлогын талаар мэдээлэл өгөв.

Их ойг тэмдэглэх ажлын хүрээнд Морь, морины эдлэл хэрэглэлийн үзэсгэлэнг Төв аймгийн “Говь Мон” жуулчны баазыг түшиглэн зохион байгуулсан.

Жуулчдад зориулсан шинэлэг хэлбэрийн нэг цэгийн үйлчилгээний “Discover Mongolia” төв нээгдлээ.

**Түлш, эрчим хүч.** “Дарханы дулааны цахилгаан станцын турбин, генераторыг шинэчлэх төсөл”-ийн зээлийн гэрээ, “Тайширын усан цахилгаан станцын төсөл”-ийн зөвлөх компанийн гэрээг сунгах тухай зэрэг асуудлыг шийдвэрлэлээ.

“Нүүрс” үндэсний хөтөлбөрийн төслийн тодотгосон хувилбарыг боловсруулан, УИХ-д өргөн бариад байна. Сэргээгдэх эрчим хүчний хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар болов.

БНХАУ-аас Монгол Улсын Засгийн газарт олгож буй 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийг Монгол Улсын эрчим хүчний бие даасан байдлыг хангахад стратегийн чухал ач холбогдол бүхий Эгийн голын усан цахилгаан станцыг барьж байгуулах ажлыг санхүүжүүлэхээр шийдвэрлэж, УИХ-ын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.

- Эгийн голын усан цахилгаан станцыг барьж байгуулснаар Төвийн эрчим хүчний сүлжээний гаднаас үл хамаарах бие даасан байдлыг хангах, цахилгаан эрчим хүчний импортыг бүрэн оруулах, импортоор авах цахилгааны төлбөр болон цахилгаан эрчим хүчний дотоод хэрэглээг бууруулснаар жилдээ 10 гаруй сая ам. долларыг хэмнэх боломжтой хэмээн үзэж байна.

Улаанбаатар хотын гэр хорооллын эрчим хүчээр хангагдаагүй байгаа айл өрхийн эрчим хүчний хангамжийг шийдвэрлэх ажилд шаардагдаж буй 2,8 тэрбум төгрөгийн

хөрөнгийн эх үүсвэрээр гүйцэтгэх ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах худалдан авах тухай Монгол Улсын хуулийн хэрэгжүүлэхээр болсон.

“Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулж байна. “Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдсантайгаар холбогдуулан “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хууль”, “Эрүүгийн хууль”, “Газрын төлбөрийн хууль”-иудад нэмэлт оруулах хуулийн төслүүдийг хамтад нь боловсруулаад байна.

Шарын голын уурхайн ажил хүндэрч, нүүрсний олзворлолт багассантай холбогдуулан “Дархан ДЦС”, “Эрдэнэт ДЦС” ХК-ийн зуухнуудад төслийн бус Багануур, Шивээ-Овоогийн нүүрсийг хэрэглэж болох боломжийг судлах зуухны горимын туршилт хийх ажлын хэсгийг томилон ажиллуулж, 2006-2007 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцуудад тус бүр 3 зуухыг нам температурын буцламтгай үет шатаалтын технологит шилжүүлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэв.

Төвийн эрчим хүчний системд “ДЦС-2” ХК, “ДЦС-4” ХК, “ДЦС-3” “ХК-ийн өндөр даралтын хэсэг зогссон аваар гарсантай холбогдуулан аваарийг яаралтай устгах, аваар гарсан шалтгааныг тогтоож техникийн дүгнэлт гаргах ажлын хэсгүүдийг томилж шуурхай арга хэмжээ авч ажилласан.

Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэрүүдийн өвлийн бэлтгэл ажлын явцад хяналт тавин ажиллаж байна. Түлшний салбарын хэмжээгээр өвөлжилтийн бэлтгэл ажлын явц нийт дүнгээрээ 45 %-ийн биелэлттэй байна. Түлш, эрчим хүчний салбарын компаниудын засвар, шинэчлэлийн ажлын график хяналт тавин ажиллаж байна. Эрчим хүчний үйлдвэрүүд 2006 онд 20 үндсэн тоноглолд их болон дунд засвар, шинэчлэл хийхээр төлөвлөснөөс энэ оны 6 дугаар сарын 20-ны байдлаар 5 засварын графикайн биелэлт 86 хувийн хэрэгжилттэй байна.

Дөргөн-Мянгад сумын ЦДАШ, дэд станцын Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Алтай трест” ХХК шалгарч ажилдаа ороод байна. Улаангом-Малчин сумын 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станц барих ажлын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын Техник эдийн засгийн үндэслэлийг хийж түлш, эрчим хүчний салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралд оруулж батлуулсан.

Баянтээг-Нарийнтээл сумын 10 кВ, Мөрөн-Алаг-Эрдэнэ-Хатгал сумын 35 кВ, Улаангом-Малчин-Хяргас сумын 110 кВ, Биндэр-Батширээт сумын 15 кВ, Халзан-Баяндэлгэр сумын 15 кВ, Дөргөний УЦС-Дөргөн сум 10 кВ, Есөнбулаг-Шарга сумын 35 кВ, Баянжаргалан-Өндөршил сумын 35 кВ, Чойбалсан-Сэргэлэн сумын 35 кВ-ын ЦДАШ, дэд өртөөний барилга угсралтын ажлын зураг төслийн гүйцэтгэгчийг шалгаруулж, экспертиз хийлгэн хүлээн аваад байна.

Говийн бүс, Архангай, Говь-Алтай, Завхан, Сүхбаатар, Ховд аймгийн төвийн түлшний хангамжийг сайжруулах ажлын хүрээнд:

- *Завхан, Ховд аймгийн төв, Говь-Алтай аймгийн Хөв булагийн нүүрсний уурхайг түшиглэн жижиг оврын шахмал түлшний үйлдвэр байгуулах*
- *Говь-Алтайн Цахиурт, Мааньт, Ховдын Хөшөөт, Хөвбулагийн уурхайд жижиг оврын уул тээврийн тоног төхөөрөмж нэвтрүүлэх*
- *Архангай, Завхан аймгийн нутаг дэвсгэрт 2005 онд хийгдсэн эрэл хайгуулын ажлын үр дүнг, харгалзан цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох зорилттой ажиллаж байна.*

Баруун бүсийн эрчим хүчний системээс 3 аймгийн түгээх сүлжээнүүдэд эрчим хүч нийлүүлэх бөөний үнийн шинэчлэлийн тооцоо хийж, үнэ тогтоох санал бэлтгэн компаниудын удирдлагуудтай тохиролцон, ЭХЗГ-т чиглэл болгон өгч батлуулан мөрдүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2006 онд шинээр эхлэх болон шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2006 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

хянаж, батлагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу эхний 6 сарын байдлаар барилга, угсралтын ажлыг санхүүжүүлээд байна.

*/сая төгрөгөөр/*

| Д/Д | Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил    | Төсөвт өртөг    | 2006 оны эхний хагас жилийн санхүүжилтийн төлөвлөгөө | 2006 оны эхний хагас жилийн санхүүжилтийн гүйцэтгэл | Зөрүү /Хувиар/ |
|-----|--|-----------------|--|---|----------------|
| 0   | 1  | 2               | 3  | 4   | 5              |
|     | <b>1. Эрчим хүч</b>                              | <b>74,296.0</b> | <b>7,900.0</b>                                       | <b>6,406.5</b>                                      |                |
| 1   | 1.1 Гадаадын зээл тусламжийн дотоод эх үүсвэр    | 18,888.9        | 3,535.4  | 3,013.4   | 81.0           |
| 2   | 1.2 Дулааны цахилгаан станц, дулааны шугам       | 1,635.8         | -  | -   | -              |
| 3   | 1.3 6, 10, 15, 35 110, 220 кВ-ын ЦДАШ, дэд станц | 33,557.3        | 4,294.6  | 3,393.1   | 79.0           |
| 4   | 1.4 Сэргээгдэх эрчим хүч                         | 20,214.0        | 70.0   | -   | 100.0          |
| 5   | <b>2. Түлш</b>                                   | <b>800.0</b>    | <b>400.0</b>   | <b>-</b>  |                |
| 6   | <b>3. Бусад</b>                                  | <b>160.0</b>    | <b>156.0</b>   | <b>28.2</b>   | <b>18.0</b>    |
|     | <b>Түлш, эрчим хүчний салбарын нийт дүн</b>      | <b>65,256.0</b> | <b>8,456.0</b>                                       | <b>6,434.7</b>                                      | <b>76.4</b>    |

Гадаад орон, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн зээлийн хөрөнгөөр 2006 оны эхний 5 сарын байдлаар 7,8 тэрбум төгрөг буюу 6,6 сая ам.долларыг ашиглаад байгаа ба 2006 оны 6 сард нийт 1,7 сая ам.долларын гүйцэтгэлийг хянав.

2006 оны эхний хагас жилийн байдлаар салбарын хэмжээнд 3,6 сая гаруй долларын бараа, тоног төхөөрөмжийг гааль НӨАТ-аас чөлөөлөөд байна.

**Хөдөө аж ахуй.** Манай улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд "Малын индексжүүлсэн даатгал төсөл"-ийн хөгжлийн зээлийн гэрээ байгуулагдаж, төсөл өнгөрсөн оноос хэрэгжиж эхэлсэн.

- 2009 он хүртэл үргэжлэх туршилтын хугацаанд Увс, Баянхонгор, Хэнтий аймаг хамрагдаад байгаа юм.
- Энэ даатгалаар индекст суурилсан буюу тодорхой нутаг дэвсгэрийн статистик үзүүлэлтэд үндэслэн даатгалын хохирол, нөхөн төлбөрийн хувь хэмжээг тооцоолох аргыг бэлчээрийн мал аж ахуйд туршин нэвтрүүлэхээр зорьж байгаа юм.
- Төслийн үр дүнгээр малчдын амьжиргаа дээшилж, даатгалын компаниудад зах зээлийн зарчмаар хөгжих боломж нээгдэж байгаа нь байгалийн гамшгийн үед Засгийн газарт ноогдох ачааг хөнгөвчлөх юм.

"Экологийн цэвэр бүтээгдэхүүн", "Малын чанар сайжруулах" үндэсний хөтөлбөрийг батлуулав.

Япон Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжих "Санхүүгийн чадвар муутай ядуу фермерүүдэд дэмжлэг үзүүлэх КР-2" төслийн НОТ бичигт гарын үсэг зурж, энэ оноос эхлэн хэрэгжихээр болов.

"ХХАА-н салбарын удирдах ажилтны зөвлөгөөн", төрөлжсөн семинарыг амжилттай зохион байгууллаа.

"НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа.

- Махыг нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх нь хавар махны үнэ хөөрөгдөхөөс сэргийлэх нэг арга хэмжээ болох бөгөөд махны үнэ огцом өссөн гол шалтгааны дотор махны үйлдвэрүүд нэмэгдсэн

*өртгийн албан татвараас зайлсхийхийн тулд экспортод хямд үнээр мах гаргаж байна гэж үзэн махны үйлдвэрүүдийн боловсруулж дотооддоо борлуулсан махыг НӨАТ-аас чөлөөлснөөр махны үнийн өсөлтийг бууруулах, улмаар түүний хангамж сайжрах нэг боломж бүрдэх юм.*

Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд нөөцөлсөн махыг борлуулж байна. “Нөөцийн махыг хадгалах, борлуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталж, мөрдүүлэв.

Дархан-Уул аймагт “Газар тариалангийн технологийн шинэчлэл” үйлдвэрлэлийн зөвлөгөөнийг зохион байгуулж, 500 гаруй тариаланчид оролцов. Зөвлөгөөнөөр Газар тариалангийн салбарт баримтлах технологийн шинэчилсэн зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэлэлцүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт Хөгжлийн албан ёсны тусламж, ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа үр дүн, одоо хэрэгжиж буй бодит ажлыг харуулсан үзэсгэлэнг зохион байгуулав.

Монгол Улсын ХХААЯ, БНСУ-ын Хөдөө аж ахуй, ойн яам хоорондын Хөдөө аж ахуйн хамтарсан хорооны ээлжит II хурал боллоо.

- *Монгол Улсын мах, сүүний үйлдвэрүүдэд НАССР нэвтрүүлэх төслийг 2007-2008 онд хамтран хэрэгжүүлэх, хоёр орны салбарын хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийн асуудлыг зохицуулах зорилгоор Монгол-Солонгосын хөдөө аж ахуйн төвийг Улаанбаатар хотноо байгуулах, Монгол Улсад мал, амьтны вирусын гаралтай өвчнийг судлах оношлогооны төв байгуулах, Монгол хонь, ямааны махны чанарыг сайжруулах судалгааны төсөл хэрэгжүүлэх зэрэг олон бодит асуудлууд протоколд тусгагдлаа.*

МАСЗХ-той хамтран “Залуу малчдын улсын анхдугаар зөвлөлгөөн”-ийг зохион байгуулав. Зөвлөлгөөнд Монгол Улсын бүх сумдаас төлөөлөгчид оролцлоо.

“Бэлчээрийн удирдлага, зохион байгуулалтыг зохицуулах Үндэсний зөвлөлийн анхдугаар хурал”-ыг зохион байгуулав. Хурлаар уг зөвлөлийн 2006 оны ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, гишүүдийн саналыг авч тусган эцэслэн боловсруулав.

Улсын хэмжээгээр нийт 145.5 мянган га талбайд тариалалт хийснээс үр тариа 115.0 мянган га-д, тосны ургамал 12.8 мянган га-д, тэжээлийн ургамал 2.8 мянган га-д, төмс 9.8 мянган га-д, хүнсний ногоо 5.1 мянган га-д тус тус тариалсан байна.

Төвийн бүсийн малчдын зөвлөгөөнийг Дархан-Уул аймагт зохион байгуулав. Зөвлөгөөнд аймгуудын удирдлага, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, малчдын төлөөлөл болох 200 орчим төлөөлөгчид оролцож санал бодлоо солилцлоо.

Царцааны тархалт, хөнөөлийн тодотгох судалгааны дүнг үндэслэн хими, биологийн аргаар царцаатай тэмцэх ажлыг Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймгуудын ХХААГ-тай хамтран зохион байгуулж, нийт ажлын 70 хувийг гүйцэтгээд байна.

Байгаль орчинд халгүй аргаар оготготой тэмцэх ажлыг Говь-Алтай, Баянхонгор, Завхан, Төв аймагт нийт 160.0 мянган га талбайд зохион байгуулав.

Эх зөгий нийлүүлэхээр гэрээ байгуулсан Зөгийн аж ахуйн эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн станцын ОХУ-аас импортоор оруулж ирсэн 190 бүл зөгийг хүлээн авч, зөгийн үржүүлэгч 9 иргэн, аж ахуйн нэгжид хуваарилан, олгох ажлыг зохион байгуулав.

Орос-Монголын хамтарсан “СВС” ХХК-ны боловсруулсан Зооноз өвчнүүдээс эрүүлжүүлэх төсөлд нэмэлт тодотгол хийв. Уг төсөлд 10 аймгийн 12.5 сая мал хамрагдана.

ХХАА-н сайд Арабын БН Египет улс, Израйль Улсад ажлын айлчлал хийж, Израйлийн Хөдөө аж ахуйн, хөдөөгийн хөгжлийн сайд, Египетийн хөдөө аж ахуй, газрын шинэтгэлийн сайд нартай хоёр улсын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашид хамтран ажиллах талаар яриа, хэлэлцээр хийв. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичигт хоёр тал гарын үсэг зурлаа.

БНСУ-ын Хөдөө аж ахуй, ойн сайдын Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр ХХАА-н сайдтай хамтын ажиллагааны чиглэлээр яриа, хэлэлцээ хийж, дор дурдсан санамж бичгүүдэд талууд гарын үсэг зурав. Үүнд:

- Монгол Улсын эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн “Хүнс Тех” корпорац, БНСУ-ын Хүнсний эрдэм шинжилгээний хүрээлэн хооронд хамтран ажиллах санамж бичиг
- Монгол Улсын Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн “Мон-Эм-Зим” компани БНСУ-ын Хүнсний эрдэм шинжилгээний хүрээлэн хооронд хамтран ажиллах санамж бичиг

Бүгд Найрамдах Казакстан Улсын Дорнод Казакстан мужийн амбан захирагчийн Монгол Улсад хийх айлчлалыг Гадаад хэргийн яамтай хамтран зохион байгууллаа. Мөн энэ айлчлалын үеэр салбарын чиглэлийн бизнес уулзалтыг зохион байгуулав.

Харилцаа, холбоо. Төрийн байгууллагуудыг вэб хуудас, ажилтан бүрийг цахим шуудангийн хаягтай болгох төслийн хүрээнд төрийн байгууллагуудын вэб боловсруулах, байршуулахад шаардлагатай 3 сервер компьютерийг нийлүүлж суурилуулах, төрийн байгууллагуудад суурилуулах агуулгын удирдлагын систем, худалдан авалтыг зуучлах портал сайтыг серверт байршуулах ажлуудыг хийгээд байна.

“Infosec Mongolia-2006” олон улсын хурал, “Монгол програм хангамж-2006” үзэсгэлэн худалдаа, “МХХТ-85” үзэсгэлэн худалдааг тус тус зохион байгууллаа.

“Цахим засаглал” мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор БНСУ-ын RENOVOТ групптэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, хэрэгжүүлж эхлээд байна.

Украин Улсаас худалдан авч хөдөөгийн холбоонд ашиглаж буй тоон радио релейны шугам үйлдвэрлэгч компанитай хамтран ажиллах чиглэлээр Санамж бичиг байгууллаа.

Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын конвенцид Монгол Улс нэгдэн орох тухай хуулийн УИХ-ын чуулганаар соёрхон батлуулав.

БНЭУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар байгуулах зайн сургалт, зайн оношлогооны төвийн талаар Энэтхэгийн талтай уулзаж, ярилцлаа. Төслийг хэрэгжүүлэхээр яам дундын ажлын хэсэг байгуулахаар боллоо.

Хөрш орнуудын Засгийн газар, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгч компаниуд, Олон улсын холбогдох байгууллагуудтай зохих яриа хэлцэл явуулж гэрээ байгуулсны үр дүнд манай улс руу орж ирж буй интернэтийн 1Мбит/сек.-ийн үнийг жилийн мөн үеийнхтэй харьцуулахад 10 дахин бууруулж дотоодын интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд 1Мбит интернэтийн урсгалд 400 ам.доллар төлөх, эцсийн хэрэглэгчид хямд бөгөөд чанартай, өндөр хурдны үйлчилгээ хүртэх, өндөр хурдны өргөн зурвасын технологиос сонголт хийх боломжийг бүрдүүлээд байна.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр тус газрын оролцоотой хэрэгжүүлж буй “Last Mile Initiative” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй, холбооны үйлчилгээ хүргэх боломж багатай орон нутгийн сумдыг сонгох шаардлагатай уялдуулан Увс аймгийн Түргэн, Давст сумдыг сонгоод байна.

БНЭУ-ын Засгийн газрын тусламжаар хэрэгжих зайн сургалт, зайн анагаах ухаан төслийг судалгааны ажлын хэсгийн Энэтхэг зөвлөхүүд Монголд айлчлав.

БНЭУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд байгуулсан “Олон нийтийн мэдээллийн төв”-ийг нээлээ.

Иргэд, айл өрх бүрт интернэтийг нэвтрүүлэх, хэрэглээг дэмжих, интернэт хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилготой “Өрх бүрт интернэт” хөтөлбөрийн сайтыг /<http://www.internet.gov.mn/> “БизОнлайн ХХК-тай хамтран боловсруулж интернэтэд байршууллаа.

Гачуурт тосгон дахь Телевизийн нэвтрүүлэгч антений суурилуулалтын ажлыг дуусгаж хүлээн авч ашиглалтад оруулав.

## 5. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО

Манай улсад хадгалагдаж байгаа газрын минийн асуудлыг үе шаттай ил болгохоор “Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулав.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгч, ЗХ-ний Ерөнхий командлагчаар батлуулахаар өргөн барилаа.

“Орон нутгийн хамгаалалтын үзэл баримтлал”-ын төслийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жил, Монгол Улсын Зэвсэгт хүчний 85 жилийн ойд зориулан “Монгол цэрэг-800” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

- *Бага хурлын зорилго нь Суут богд Чингис хааны байгуулсан Их Монгол Улсын цэргийн дэлхий, бүс нутаг, монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг уламжлал-шинэчлэлийн хүрээнд, судалгааны ажлын өнөөгийн төвшинд авч үзэхэд оршиж байв.*

Монгол Улсад цэрэг техникийн тусламж үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын БХЯ, ОХУ-ын “Конструкторское бюро приборостроение” ТӨҮГ хооронд байгуулсан гэрээний дагуу нийлүүлсэн зэвсэг, галт хэрэглэл, Герман Улсаас нийлүүлсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн гаалийн бүрдүүлэлтийг хийж, хүлээн авсан.

“Зэвсэгт хүчний байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг 2008 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, “Цэргийн цагдаа” төсөл, 2006 онд бүрдүүлэх “Цэргийн нөөц”-ийн тухай, “Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын гэрээт харуулын үйл ажиллагааг боловсронгуй болгох” зэрэг асуудлуудыг шийдвэрлэв.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Бүх цэргийн хар сүлдний өргөөнд байрлуулах зэр зэвсэгийг худалдан авах хөрөнгө гаргах тухай, өргөө барих зардлын төсөл, тооцоог сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, “Хар сүлд”-ний өргөө барих ажил хийгдэж байна.

“Хааны эрэлд-06” Олон улсын энхийг сахиулах ажиллагааны дунд шатны төлөвлөлтийн бага хурлыг зохион байгууллаа.

- ✓ *АНУ-ын Номхон далайн цэргийн командлал, Дэлхийн энхийг дэмжих ажиллагааны сан, Ружи, Тонга, Тайланд улсын төлөөлөгчид оролцлоо.*
- ✓ *Хурлаар “Олон улсын төлөвлөлтийн өргөтгөсөн баг”-ийн КШС, “Хааны эрэлд-06” олон улсын энхийг сахиулах ажиллагааны хээрийн сургуулийн зохион байгуулалт, төлөвлөлт, оролцох бүрэлдэхүүн, ар талын хангалтын бэлтгэл ажлын талаар хэлэлцэж, урьдчилсан тохиролцоонд хүрэв.*

Монгол-Америкийн цэргийн хуульчдын анхдугаар уулзалт-онолын бага хурлыг зохион байгуулан явууллаа.

Батлан хамгаалах яам “Нээлттэй мэдээллийн өдөрлөг” зохион байгуулж Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын тохируулагч агентлаг, ЗХ-ний анги, харьяа байгууллага, аж ахуйн нэгж бүрэн хамрагдлаа. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Ирак, Афганистанд үүрэг гүйцэтгэсэн зарим багийн бүрэлдэхүүнд хүндэтгэл үзүүлэн Төрийн дээд одон медиалаар шагналаа.

Монгол, Германы БХЯ-дын зөвлөлдөх уулзалтыг 2006 оны 6 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулав.

Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн Тэсрэх аюул бүхий зүйлсийн хайгуул устгалын томилгоот бүлгүүдийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг Инженерийн цэргийн хэлтэстэй хамтран шалгаж, холбогдох арга хэмжээг авсны зэрэгцээ уг бүлгүүдийн үүрэг гүйцэтгэх

чадавхийг сайжруулах зорилгоор УАЗ-452 автомашиныг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тусгай тоноглолоор тоноглох ажлыг эхлүүлээд байна.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн ҮІ ээлжийн бүрэлдэхүүн Олон үндэстний дивиз /төв-өмнөд/-ийн штаб байрлах Ад Дивиняах хот дахь “Эко” баазын аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын үүргээ амжилттай биелүүлж байна. Бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, сэтгэл санааны байдал, ахуй хангалт хэвийн байна.

Сиерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн багийнхан тус улсын Фрийтаун хот дахь НҮБ-ын Нарлаг баазад байрлан уг бааз болон Тусгай шүүх дээр 2 хуваагдан үүрэг гүйцэтгэж байна. Бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, сэтгэл санааны байдал, ахуй хангалт хэвийн байна.

Сиерра Леонд Тусгай шүүхийн аюулгүй байдлыг хангах НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багийн II ээлжийн бүрэлдэхүүнийг сонгон авч, Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд байрлуулан ажиллагааны өмнөх сургалтыг явуулж бэлтгэлийг нь хангуулан илгээхэд бэлэн боллоо.

“Орон сууц” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн зохион байгуулж, 29 айлын орон сууцны барилгыг ашиглалтанд оруулах “Орон сууц 2010” хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-аас ирүүлсэн тусламжийн барааг зарж борлуулан, орон сууцны барилга барих хөрөнгө төвлөрүүлэх ажил үргэлжлэн хийгдэж байна.

“Орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 420 айлын орон сууцны цэргийн хотхон байгуулах ерөнхий төлөвлөгөө батлуулж, техникийн нөхцөл бүрдүүлж, хөрсний геологийн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргууллаа.

2006 оны I ээлжийн цэрэг татлагаар цэргийн албанд шинээр татагдан ирсэн цэргийн албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын давтан үзлэгт хамруулж, эрүүл мэндийн хувьд цэргийн албанд тэнцэхгүй 11 хүний цэргийн албаны асуудлыг шийдвэрлэсний гадна Зэвсэгт хүчний марш, тактикийн аварга тасаг, салаа, оны мэргэжлийн аварга офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагч шалгаруулах тэмцээнд оролцох бие бүрэлдэхүүнд нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг хийж, дүгнэлт гаргалаа.

Гамшгаас хамгаалах. “Шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоол, “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар гарган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

2006 он гарсаар Дорнод, Баянхонгор, Сэлэнгэ аймагт малын халдварт боом өвчин 3 удаа, хүнд халдварласан тохиолдол Дорнод, Увс аймагт 2 удаа гарлаа. Боом өвчнөөр хорогдсон малыг булж устган, ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, вакцинжуулалтанд 82 хүн, 1479 толгой мал хамрагдаж боом өвчний халдвараас хамгаалагдсан байна. Мал, амьтны халдварт галзуу өвчин Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай, Хөвсгөл, Ховд аймгийн 7 суманд 13 удаа гарч, галзуу өвчнөөр өвчилсөн 33 мал, 27 чоно, үнэг, тэжээвэр нохойг устган булж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн ба вакцинжуулалтанд 162 хүн, 5509 толгой мал хамрагдаж, галзуу өвчний халдвараас хамгаалагдсан байна.

2006 он гарсаар 7 аймгийн 9 сум, нийслэлийн 2 дүүрэгт 11 удаа ой, хээрийн түймэр гараад байна. Ой, хээрийн түймрийг унтраах ажилд Онцгой байдлын төв орон нутгийн байгууллагаас 2005 онд 1194 албан хаагч, 4159 хүн, 2 нисдэг тэрэг, 384 автомашин, техник, 2006 онд 54 албан хаагч, 400 хүн, 39 автомашин, техник оролцжээ.

## **6. ГАДААД БОДЛОГО**

Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болох хөрш орнууд-ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй, эрх тэгш харилцан ашигтай байх зарчимд тулгуурласан өргөн цар хүрээтэй хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ОХУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд саяхан ОХУ-ын Гадаад хэргийн сайдыг хүлээн авч айлчлууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс БНХАУ-д 2005 онд хийсэн төрийн айлчлалын үеэр хийсэн тохиролцоонуудыг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна.



УИХ-ын дарга БНСУ, Швед, Норвеги, Финлянд, Данийн Вант Улс, Бүгд Найрамдах Финланд Улс, Норвегийн Вант Улсад, Ерөнхий сайд Япон, айлчилж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар тодорхой тохиролцоонуудад хүрсэн. Монгол Улсын Ерөнхий сайд Япон Улсад хийсэн айлчлалын үеэр 2 шаттай иөнийн зээлийн хэлэлцээр байгуулсан нь Япон Улстай иж бүрэн тншлэлийн харилцааг баяжуулж, харилцан ашигтай байх чиглэлд хийсэн чухал алхам болов.

БНСУ-ын Ерөнхийлөгч Ну Мү Хён Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Монгол Улсад төрийн айлчлал хийв.

- *Монгол Улс, БНСУ нь Зүүн Хойд Азид орших хөрш орнуудын хувьд цаашид улс төр, эдийн засаг, соёлын бүхий л салбарт хамтын ажиллагаагаа “Сайн хөршийн, найрамдал, хамтын ажиллагааны түншлэл”-ийн зарчмын үндсэн дээр хөгжүүлэхээр тохиролцсон нь ач холбогдолтой болов.*
- *“Нийгмийн хамгааллын хэлэлцээр”, түүнийг хэрэгжүүлэх “Удирдлагын тохиролцооны гэрээ” зэрэг Засгийн газар хоорондын хэлэлцээр, Яам хоорондын хамтын ажиллагааны тухай 18 баримт бичигт гарын үсэг зурав. Солонгосын тал 25 сая ам.долларын өртөг бүхий хоёр төслийг хөнгөлөлттэй зээлийн хүрээнд санхүүжүүлэхээр болов.*

2006 оны 6 дугаар сарын 15-нд Шанхай хотноо болсон ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ажиглагчаар оролцож үг хэлэв.

- *Дээд хэмжээний уулзалтад оролцох үеэрээ Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНХАУ-ын дарга Ху Жинтао, БНКаз. Улсын Ерөнхийлөгч Н.Назарбаев болон Афганистаны Ерөнхийлөгч Х.Карзай нартай хоёр талын уулзалт хийж харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.*

Дээрх уулзалтын үеэр Монгол Улсын Гадаад хэргийн сайд Н.Энхболд, ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров нар хоёр орны ГХЯ хоорондын 2006-2007 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурав.

Монгол, Хятадын хилийг хоёр дахь удаагаа хамтран шалгасан тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын протокол, хоёр улсын хилийн зурвас газрын зургийг УИХ-аар соёрхон батлууллаа.

Солонгосын Шинхан банк Солонгост байгаа монгол иргэдийн мөнгийг Монгол руу албан ёсоор гуйвуулж байхаар болов. 2000 хүртэл ам.доллар гуйвуулахад банкны шимтгэл 18000 вон байдаг бол “Шинхан” банк манай иргэдэд хөнгөлөлт үзүүлж 9000 воноор үйлчлэх, шилжүүлгийн мэдүүлгийн монгол хэл дээрх загварыг бүх салбарууддаа тавихаар боллоо.

Ирэх 5 жилд НҮБ-аас манай оронд үзүүлэх хөгжлийн тусламжийн ерөнхий хүрээг тодорхойлсон үндсэн баримт бичигт УИХ-ын гишүүн, Гадаад хэргийн сайд Н.Энхболд, НҮБ-ын Суурин зохицуулагч хатагтай Пратиба Мета нар гарын үсэг зурав.

Монгол-Казахстаны ЗГХК-ын IV хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

- ✓ *Хурлын Протоколд хоёр орны хооронд байгуулахаар яригдаж буй зарим хэлэлцээрт гарын үсэг зурах хугацаа, түвшинг тохиролцов. Эрдэнэт үйлдвэрийн авлага барагдуулах асуудлаар санал солилцож байр сууриа илэрхийлсэн нь ач холбогдолтой болов.*

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2006 оны 4 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд 90 хүртэл хоногоор Монголд зорчих Японы иргэдийг визээс чөлөөлөх асуудлыг шийдвэрлэв.

Ерөнхий сайд М.Энхболдод Францын уул уурхайн “АРЕВА” группын төлөөлөгчид бараалхав. Тэд Монгол Улсад өөрийн салбар компаниараа дамжуулан 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаа ба цаашид манай улсад уран олборлолтын салбарт хамтран ажиллаж хөрөнгө оруулах сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Улаан-Уулд ураны орд илрүүлсэн болон Монголд цацраг идэвхт бодисоос иргэдийг хамгаалахад чиглэсэн хууль, эрх зүйн орчин боловсронгуй бус байгааг тэд тэмдэглээд энэ тал дээр хамтран ажиллах боломжтойгоо мэдэгдэв.

Ерөнхий сайд М.Энхболдод Бельгийн Вант Улсад суугаа Өргөмжит консул А.Занзер тэргүүтэй төлөөлөгчид бараалхаж Монгол Улсад аялал жуулчлалын цогцолбор барихаар төлөвлөж буйгаа танилцуулав. “Чингис хаан” нисэх онгоцны буудлын ойролцоо баригдах энэхүү байгууламжид 2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх, мөн манайд аялал жуулчлалын салбарын боловсон хүчнийг сургахад ихээхэн хөрөнгө оруулахаа мэдэгдэв.

Монгол Улсын Гадаад хэргийн сайд Н.Энхболдын урилгаар Малайзын Гадаад хэргийн сайд Дато С.Албар Монголд айлчилж, хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Айлчлалтай холбогдуулан хоёр орны Гадаад хэргийн сайд нарын хамтарсан мэдэгдэл гарав.

Швейцарийн Хөгжил, хамтын ажиллагааны газрын Ерөнхий захирал В.Фүст Монгол Улсад айлчлав. Хүмүүнлэгийн тусламж, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрт манай Гадаад хэргийн сайд Н.Энхболд, Ерөнхий захирал В.Фүст нар гарын үсэг зурав.

- Энэхүү айлчлал хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааны цар хүрээг тодорхойлох, хөгжлийн тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх, цаашдаа Швейцарийн хөгжлийн хамтын ажиллагааны бодлогод Монгол Улсын зэрэглэлийг дээшлүүлэх, хамтын ажиллагааны механизм тогтооход чухал ач холбогдолтой болов. Дээрх хэлэлцээр Улаанбаатар дахь ШХХАА-ийн төлөөлөгчийн газрын статусыг дипломат төлөөлөгчийн хэмжээнд хүргэв.

2006 оны 6 дугаар сарын 8-9-нд Европын Холбооны “Тройка”-гийн төлөөлөгчид Монгол Улсад анх удаа айлчилж, ЕХ-ны зүгээс Монгол Улстай харилцаагаа идэвхжүүлэх, Монгол Улсын “гурав дахь хөрш” болох эрмэлзэлтэйгээ илэрхийлсэн нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болов.

Монгол Улс, Европын Холбооны Хамтарсан хорооны 9 дүгээр хуралдаан, Монгол Улс, ЕХ-ны Худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын дэд хорооны хуралдаан Улаанбаатар хотноо тус тус болж, Хамтарсан хорооны хуралдаанаас Монгол Улс, Европын Холбооны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн түвшинг дүгнэж, цаашид хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлон “Хамтарсан мэдэгдэл” гаргав. Хуралдааны үеэр ЕХ нь Хамтын ажиллагааны төлөөлөгчийн газраа Монголд албан ёсоор нээсэн нь хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, ЕХ-ны зүгээс Азийн бүс нутагт явуулж буй тусламжийн олон төрлийн хөтөлбөрт Монгол Улсыг хамруулахад ач холбогдолтой болов.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд Нидерландын Ханхүү Александр, Гүнж Максима нар Монголд айлчлав. Ханхүү, Гүнж нар Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга нарт бараалхав. Дээрх уулзалтын үеэр талууд хоёр орны байгаль орчны салбарын хамтын ажиллагаа тухайлбал, усны менежментийн туршлага солилцох боломжийн талаар ярилцав. Айлчлалын үеэр Ханхүү, Гүнж нар Хустайн нурууны тусгай бүсэд зочилж, малчин айлын амьдрал ахуйтай танилцав. Айлчлал Монгол Улсын хөгжлийн гадаад таатай орчныг бүрдүүлэх, Европын Холбооны орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг урагшлуулах зорилтын хүрээнд амжилттай болов.

БНКаЗ. Улсын Алматы хотноо болсон Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх зөвлөгөөн /СВМДА/-ий дээд хэмжээний хоёр дахь уулзалтад Монгол Улсын Шадар сайд М.Энхсайхан тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Уулзалтаар тус байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газрын дүрмийг батлан байгуулж, Төгсгөлийн тунхаг бичиг гаргав. Манай төлөөлөгчдийн тэргүүн тус байгууллагын цаашдын үйл ажиллагааны чиглэлээр байр сууриа илэрхийлсэн үг хэлж, уулзалтаас гаргасан баримт бичгүүдэд гарын үсэг зурав.

АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхим Монгол Улсыг дэмжсэн тогтоолыг батлав.

- Конгрессын Төлөөлөгчдийн танхимын дарга Д.Хастертын 2005 онд манай оронд хийсэн айлчлалын үеэр яригдсан болон айлчлалын мөрөөр ажилласны үр дүн болох Конгрессын энэхүү тогтоол АНУ-ын Засаг захиргаанд хандаж АНУ-Монголын талын харилцааг хөгжүүлэх тодорхой уриалга дэвшүүлснээрээ чухал ач холбогдолтой болов.

Катарын Доха хотноо болсон Азийн хамтын ажиллагааны яриа хэлцээ (АСД)-ний Сайд нарын V уулзалтад Гадаад хэргийн сайд Н.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнууд (АШСТО)-ын V бага хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хэлэлцэх олон улсын бага хурлыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.

- Хуралд 17 орны засгийн газрын төлөөлөгчид, 20 гаруй олон улсын эрдэмтэн, судлаачид оролцов. Бага хурлаар 2003 онд Улаанбаатар хотноо хуралдсан АШСТО-уудын V бага хурлын шийдвэрийн хэрэгжилтийн явц байдал, үр дүн болон энэ оны 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 1-нд Катарын Доха хотноо болох АШСТО-уудын VI бага хурлын бэлтгэл ажлын талаар хэлэлцэв.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх тухай хуулийн төслийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаан, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэв.

Мьонхен хотын Угсаатны зүйн музейн захирал Др.К.Мюллер Монголд ирэхдээ 2007 оны 4 дүгээр сараас Испанид гарах “One day in Mongolia” үзэсгэлэнд тавигдах зүйлээс зарим үзмэрийг Мьонхен хотын Угсаатны зүйн музейд байнга байрлуулах талаар манай холбогдох албаны хүмүүстэй ярилцав. 200 кв.метр талбайд байрлах энэ үзмэр нь Германы томоохон музейнүүдийн дотор анх удаа Монголын тухай бие даасан байнгын үзмэр болох юм.

## **ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ**

Өршөөл үзүүлэх тухай хуулийг УИХ-аар батлуулж, “Авилгалаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-аар хэлэлцүүллээ.

Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл, Боловсролын тухай, Ашигт малтмалын тухай, Үндэсний их баяр наадмын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл заалтыг хүчингүй болгох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудын төсөлд санал авч эцэслэн боловсруулав.

“Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зарим арга хэмжээний тухай”, “Зэвсэгт хүчний ...дүгээр ангийн барилгыг ХХЕГ-т шилжүүлэх тухай”, “Монгол Улсын дипломат, албан болон үндэсний энгийн гадаад паспортыг хэвлүүлсэн зардлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх зэвэрийг гаргах тухай” Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

Манай Улсад хууль бусаар оршин суугаа гадаадын иргэд /харьяалалгүй хүн/-ийн бүртгэл, хяналт болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт болон төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авч байна.

БНУУ-ын Хууль зүйн сайдын урилгаар Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд тэргүүтэй төлөөлөгчид тус улсад ажлын айлчлал хийж байна.

*Айлчлалын үеэр Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр БНУУ-ын Хууль зүйн сайд, Ерөнхий прокурорын орлогч, Шүүхийн зөвлөлийн дарга, Их Хурлын орлогч дарга, Дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндсэн хуулийн цэцийн дарга нартай уулзах бөгөөд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам БНУнгарУ-ын Хууль зүйн яам хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурах юм.*

Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдпөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох” чиглэлээр төсөл хэрэгжүүлэх

болсонтой холбогдуулан Европын сэргээн босголт хөгжлийн банкны төлөөлөгчид манай улсад ажлын айлчлал хийлээ.

“Гадаад паспортыг шинээр хэвлүүлэх зардалд зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хөрөнгө гаргуулах тухай”, “Архив албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай”, “Хөрөнгө шилжүүлэх тухай /Эрх зүйн мэдээллийн 28 байгууллагыг холбосон физик холболтыг Тагнуулын ерөнхий газрын Төрийн холбоонд шилжүүлэх тухай/” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ш.Сүхбаатар ХБНГУ-ын Хайдельберг хотын Макс Планкийн институтийн урилгаар “Монгол Улсын захиргааны хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь” сэдэвт санал солилцох уулзалтад оролцлоо. Уг институт нь Монгол Улсын захиргааны ерөнхий хууль боловсруулах ажилд тодорхой дэмжлэг үзүүлэхээ илэрхийлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамыг түр хамраагч Брайн Голд Бэк тэргүүтэй төлөөлөгчид болон БНУУ-аас МУ-д суугаа Элчин сайд Иллэши Михай, БНХАУ-ын Дээд шүүхийн дарга тэргүүтэй төлөөлөгчид, Европын Сэргээн босголтын банкны Ерөнхийлөгчийн улс төрийн зөвлөх Махир Бабаев, дэд сайд Ш.Сүхбаатар Улаан загалмайн нийгэмлэгийн Бээжин дэх бүс нутгийн төлөөлөгчийн газрын дарга Деннис Алистоун, ХБНГУ-ын Хессэн муж дахь Монгол Улсын өргөмжит Консул ноён Дирк Пфайгл нарыг тус тус хүлээн авч уулзлаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр Австри Улсад албан ёсны айлчлал хийж байна.

Төрийн нууцын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор “Хууль зүй, дотоод хэргийн яаманд төрийн нууц хамгаалах журам”, “Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтаны жагсаалт”-ыг шинэчлэн баталлаа.

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангах, өрсөлдөөний тухай ойлголтыг нийгмийн сэтгэл зүйд төлөвшүүлэх, өрсөлдөөний орчныг бүрдүүлэх хүрээнд МҮХАҮТ-тай хоёр талын хамтын ажиллагааг тодорхойлсон “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт зохицуулалтын ажлын хүрээнд Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэр, Монгол-Оросын хамтарсан “Монголросцветмет” нэгдлээс “УБТЗ” хувь нийлүүлсэн нийгэмлэг нь монополь байдлаа ашиглан үнэ тарифаа үндэслэлгүй нэмэгдүүлж байгаа талаар ирүүлсэн гомдлын дагуу шалгаж, “УБТЗ” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн хууль зөрчсөн зарим үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргаж, үнэ тарифаа нэмэгдүүлсэн шийдвэрээ эргэж хянан үзэхийг санал болгоод байна. Мөн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт цахилгаан холбооны үйлчилгээний зах зээл дээр давамгайл байдалтай аж ахуйн нэгжийг тогтоосон судалгааны дүнг хэлэлцэн үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд Мобиком ХХК, суурин телефон холбооны үйлчилгээний зах зээлд МЦХ ХК, утасгүй суурин телефон холбооны үйлчилгээний зах зээлд Мобиком ХХК-ийг тус тус давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тогтоож тогтоол гаргав.

“Согтууруулах ундаа, үр тарианы гурил, хар төмөрлөгийн зах зээлийн өрсөлдөөн” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

“Мобиком” ХХК-д хийсэн шалгалт тус компани нь 1 минутын ярианы тарифаа бүх үйлчилгээндээ хямдруулсан мэтээр иргэдийг төөрөгдүүлсэн сурталчилгаа хийсэн байна гэсэн дүгнэлтийн дагуу хамтарсан ажлын хэсэг гарч ажилланы дүнд Мобиком ХХК нь үнэ тарифаа сурталчилгаа явуулсныхаа дагуу 6 дугаар сарын 24-ний өрдөөс эхлэн бодитойгоор хямдруулснаа мэдэгдэв.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

---- о О о ----